

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Улаанбаатар хот

2026

Агуулга

ХУРААНГУЙ.....	1
Бодлогын дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
Бодлогын зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	2
ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	2
1.1 Үнэлгээ хийх болсон үндэслэл	2
1.2 Үнэлгээний зорилго	2
1.3 Үнэлгээний зорилт.....	2
1.4 Үнэлгээний хүрээ.....	3
.....	3
1.5 Үнэлгээний шалгуур үзүүлэлт.....	3
<i>Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт.....</i>	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ	4
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	4
2.1 Хот, суурины ус хангамжийн тогтолцоо	4
<i>Хүснэгт 2. Хот, суурины ус хангамжийн салбарын институцийн бүтэц.....</i>	5
2.2 Ус хангамжийн үйлчилгээний хүртээмж.....	5
<i>Хүснэгт 3. Хотын усны хэрэглээний бүтэц.....</i>	5
2.3 Бохир усны менежментийн тогтолцоо.....	6
2.4 Салбарын хөгжлийн ерөнхий үнэлгээ.....	6
<i>Хүснэгт 4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын SWOT шинжилгээ.....</i>	7
ГУРАВДУГААР БҮЛЭГ	8
ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	8
3.1 Хуулийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ.....	8
Хэрэгжилтийн байдал.....	9
Илэрч буй асуудал	9
Үр дагавар.....	10
Дүгнэлт.....	10
3.2 Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ.....	10
Хэрэгжилтийн байдал.....	11
Илэрч буй асуудал	11
Үр дагавар.....	12
Дүгнэлт.....	12

Хүснэгт 6. Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ	12
3.3 Ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ.....	13
Хэрэгжилтийн байдал.....	13
Илэрч буй асуудал	14
Үр дагавар.....	14
Дүгнэлт.....	14
Хүснэгт 7. Ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ	15
3.4 Бохир ус зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ	15
Хэрэгжилтийн байдал.....	15
Илэрч буй асуудал	16
Үр дагавар.....	16
Дүгнэлт.....	17
Хүснэгт 8. Бохир ус зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ.....	17
3.5 Хяналт, хариуцлагын зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ.....	17
Хэрэгжилтийн байдал.....	18
Илэрч буй асуудал	18
Үр дагавар.....	19
Дүгнэлт.....	19
Хүснэгт 9. Хяналт, хариуцлагын зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ	19
3.6 Хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	19
Хүснэгт 10. Хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	20
Нэгдсэн үнэлгээ.....	20
3.1 Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилт	21
<i>Хүснэгт 5. Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ</i>	<i>22</i>
3.2 Ус хангамжийн үйлчилгээний зохицуулалтын хэрэгжилт	22
<i>Хүснэгт 6. Ус хангамжийн үйлчилгээний зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ</i>	<i>23</i>
3.3 Бохир усны менежментийн зохицуулалтын хэрэгжилт	23
<i>Хүснэгт 7. Бохир усны менежментийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ</i>	<i>24</i>
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	25
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН НАРИЙВЧИЛСАН ШИНЖИЛГЭЭ	25
4.1 Эдийн засгийн үр дагавар	25
4.2 Нийгмийн үр дагавар.....	25

4.3 Байгаль орчны үр дагавар	26
4.4 Институцийн үр дагавар.....	26
4.5 Нэгдсэн үнэлгээ.....	27
4.6 Урьдчилан тооцоогүй үр дагавар	27
ТАВДУГААР БҮЛЭГ	27
ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ШААРДАГДАЖ БУЙ ЗОХИЦУУЛАЛТЫН НАРИЙВЧИЛСАН ШИНЖИЛГЭЭ	27
5.1 Хуулийн зорилт ба бодлогын хүрээний зохицуулалтын асуудал	27
5.2 Институцийн зохицуулалтын асуудал	28
5.3 Тарифын зохицуулалтын асуудал	28
5.4 Бохир усны дахин ашиглалтын зохицуулалтын асуудал	29
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	29
ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	30
6.1 Монгол Улсын усны нөөцийн ерөнхий төлөв.....	30
6.2 Хот, суурины ус хангамжийн тогтолцоо	30
6.3 Усны хэрэглээний бүтэц.....	30
6.4 Ус хангамжийн дэд бүтцийн хөгжил	30
6.5 Бохир усны менежмент	31
6.6 Ус дахин ашиглах боломж	31
6.7 Ус дахин ашиглах чиглэлээрх олон улсын туршлага.....	31
6.7.1 Израилийн туршлага.....	32
6.7.2 Сингапурын туршлага	32
6.7.3 Австралийн туршлага	32
6.7.4 АНУ-ын туршлага.....	33
6.7.5 Монгол Улсад хэрэгжүүлэх боломж	33
6.8 Улаанбаатар хотын ус хангамж, бохир усны менежментийн тохиолдол судалгаа	34
6.8.1 Улаанбаатар хотын ус хангамжийн систем.....	34
6.8.2 Хотын усны хэрэглээний бүтэц	35
6.8.3 Улаанбаатар хотын бохир усны менежмент.....	35
6.8.4 Бохир ус дахин ашиглах боломж.....	36
6.8.5 Бодлогын дүгнэлт.....	36
6.9 Монгол Улсын хотуудын ус хангамж, ариутгах татуургын системийн харьцуулсан шинжилгээ	37
6.9.1 Хотуудын ус хангамжийн системийн ерөнхий үзүүлэлт	37

6.9.2 Ус хангамжийн дэд бүтцийн харьцуулалт.....	37
6.9.3 Бохир ус цэвэрлэх системийн харьцуулалт	38
6.9.4 Хотуудын усны менежментийн тулгамдсан асуудал	38
6.9.5 Бодлогын дүгнэлт.....	39
6.10 Монгол Улсын хот, суурины усны балансын шинжилгээ	39
6.10.1 Хот, суурины усны нийлүүлэлт.....	39
6.10.2 Хотын усны хэрэглээний бүтэц.....	40
6.10.3 Усны алдагдлын шинжилгээ.....	40
6.10.4 Бохир усны урсгал ба дахин ашиглах боломж.....	41
6.10.5 Усны балансын бодлогын үнэлгээ	41
ДОЛООДУГААР БҮЛЭГ.....	42
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ.....	42
7.1 Хуулийн зорилгод хүрсэн түвшний үнэлгээ	42
The 7.2 Зардлын өөрчлөлтийн үнэлгээ.....	43
НАЙМДУГААР БҮЛЭГ.....	46
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД СААД БОЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ.....	46
8.1 Эрх зүйн хүчин зүйл.....	46
8.2 Институцийн хүчин зүйл.....	47
8.3 Эдийн засгийн хүчин зүйл	47
8.4 Техник, технологийн хүчин зүйл	47
8.5 Нийгмийн хүчин зүйл.....	47
8.6 Нэгдсэн дүгнэлт	48
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ	48
ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ ШААРДАГДАЖ	48
БУЙ ЗОХИЦУУЛАЛТЫН САНАЛ	48
9.1 Хуулийн зорилт, бодлогын хүрээг өргөжүүлэх	48
9.2 Институцийн зохицуулалтыг сайжруулах.....	49
9.3 Усны үйлчилгээний тарифын тогтолцоог боловсронгуй болгох	50
9.4 Бохир усны дахин ашиглалтын зохицуулалтыг бий болгох.....	50
9.5 Ус хангамжийн дэд бүтцийн шинэчлэлийг дэмжих зохицуулалт	51
9.6 Нэгдсэн бодлогын санал.....	51
АРАВДУГААР БҮЛЭГ	52
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	52
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	54
Нэг. Хууль тогтоомж	54

Хоёр. Хууль тогтоомжийн үнэлгээ, судалгааны арга зүйн баримт бичиг	54
Гурав. Төрийн бодлогын баримт бичиг	54
Дөрөв. Судалгааны тайлан, үнэлгээний баримт бичиг.....	54
Тав. Салбарын статистик, мэдээллийн эх сурвалж.....	55
Зургаа. Олон улсын байгууллагын тайлан, судалгаа.....	55
Долоо. Олон улсын туршлагын эх сурвалж	55
Найм. Цахим эх сурвалж	56
Хавсралт.....	57
1.1.Хууль хэрэгжихээс өмнөх ба дараах нөхцөл байдлын харьцуулалт.....	57
1.2.Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний матриц.....	57
Схем 1.1. Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүгнэлтийн диаграмм.....	58
1.3. Бодлогын шийдвэрийн хувилбарын матриц.....	58
1.4.Монгол Улсын хот, суурины ус хангамжийн статистик мэдээлэл.....	59
1.5.Хот, суурины бохир усны хэмжээ	59

ХУРААНГУЙ

Энэхүү үнэлгээгээр Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилт нь салбарын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн суурийг бүрдүүлж, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тогтолцоог төлөвшүүлэхэд тодорхой ахиц гаргасан нь тогтоогдлоо. Тухайлбал, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний институт бүтэц бүрдэж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа тогтворжсон, бохир ус цэвэрлэх дэд бүтцийн хөгжилд ахиц гарсан.

Гэвч салбарын өнөөгийн нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтийн үр дүнгээс үзэхэд хууль нь хөгжлийн шинэ шаардлагыг бүрэн хангахгүй байгаа нь тодорхой байна. Хотжилт, хүн амын төвлөрөл нэмэгдсэнээр усны хэрэглээ огцом өсөж, газрын доорх усны нөөцөд үзүүлэх ачаалал нэмэгдэж байгаа нь усны нөөцийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулж байна. Үүний зэрэгцээ хаягдал, бохир усыг цэвэрлэх, дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалт тодорхой бус хэвээр байгаа нь байгалийн цэнгэг усны нөөцийг үр ашигтай ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Мөн салбарын институцийн зохицуулалт, байгууллагуудын чиг үүргийн уялдаа, мэдээллийн нэгдсэн тогтолцоо сул байгаа нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна. Ус хангамжийн дэд бүтцийн элэгдэл, технологийн хоцрогдол, тарифын тогтолцооны сул тал нь салбарын санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулж, шаардлагатай хөрөнгө оруулалт цаг хугацаандаа хийгдэх байх нөхцлийг бүрдүүлсэн.

Салбарын хөгжлийн өнөөгийн чиг хандлага, хотжилт суурьшил, усны хэрэглээний өсөлт нь одоогийн эрх зүйн зохицуулалтыг шинэ шатанд гаргах шаардлагыг бий болгож байна. Хэрэв зохицуулалтыг шинэчлэхгүй тохиолдолд усны нөөцийн зохисгүй хэрэглээ, ашиглалт нэмэгдэх, дэд бүтцийн хомсдол гүнзгийрэх, үйлчилгээний чанар, хүртээмжийн ялгаа нэмэгдэх, цэнгэг усны хомсдол, байгаль орчны эрсдэл өсөх нөхцөл бүрдэхээр байна.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын тогтвортой хөгжлийг хангах, усны нөөцийн хамгаалалтыг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1 Үнэлгээ хийх үндэслэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь 2011 онд батлагдаж, хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Хууль батлагдсанаас хойш Монгол Улсад хотжилтын түвшин хурдацтай нэмэгдэж, хүн амын төвлөрөл томоохон хот, сууринд эрчимтэй өссөн байна. Үүний зэрэгцээ үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил, барилгажилт, дэд бүтцийн өргөтгөл зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр хот, суурины усны хэрэглээ ашиглалт нэмэгдэж, усны нөөцийн хомсдол нүүрлэх хандлага ажиглагдаж байна.

Ялангуяа нийслэл Улаанбаатар хотын ус хангамжийн систем нь Туул голын хөндий дэх газрын доорх усны нөөцөд тулгуурладаг бөгөөд хүн амын өсөлт, хотжилтын тэлэлттэй холбоотойгоор усны нөөцийн хомсдол, бохирдол, тогтвортой ашиглалтыг хангах асуудал улам бүр чухал болж байна.

Нөгөө талаас хаягдал, бохир усны цэвэрлэгээ, цэвэрлэсэн усыг дахин ашиглах асуудал нь усны нөөцийн тогтвортой менежментийн чухал бүрэлдэхүүн хэсэг болсон боловч холбогдох эрх зүйн зохицуулалт, стандарт, эдийн засгийн механизм хангалттай хөгжөөгүй хэвээр байна.

Иймд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээл, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй үр дагаврыг тодорхойлох, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагыг тогтоох зорилгоор энэхүү хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийв.

1.2 Үнэлгээний зорилго

Энэхүү үнэлгээний зорилго нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, хуулийн зорилго, зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох, цаашид хууль тогтоомжийг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжит бодлогын хувилбар, зөвлөмж боловсруулахад оршино.

1.3 Үнэлгээний зорилт

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг судлах
2. Хуулийн зорилго, зохицуулалтын хэрэгжилтийн түвшнийг үнэлэх
3. Хуулийг хэрэгжүүлэх явцад үүсч буй хүндрэл, бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлох
4. Хуулийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон нийгэм, эдийн засаг, байгаль орчны эерэг болон сөрөг үр дагаврыг тодорхойлох
5. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар бодлогын санал, зөвлөмж боловсруулах

1.4 Үнэлгээний хүрээ

Энэхүү үнэлгээний хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дараах үндсэн зохицуулалтын хэрэгжилтийг судлав.

- хот, суурины ус хангамжийн тогтолцоо
- бохир ус зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагаа
- салбарын байгууллагуудын эрх, үүрэг
- төрийн байгууллагын бүрэн эрхийн хэрэгжилт
- усны үйлчилгээний тарифын зохицуулалт
- бохир усны менежмент, дахин ашиглалтын асуудал.

Зураг №1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ерөнхий логик



1.5 Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасан дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
1	Зорилгод хүрсэн түвшин	Хуулийн зорилго, зорилт хэрэгжсэн эсэх
2	Зардлын өөрчлөлт	Хууль хэрэгжсэнээр гарсан зардлын өсөлт, бууралт
3	Зардал–үр өгөөжийн харьцаа	Хуулийн хэрэгжилтийн эдийн засгийн үр ашиг
4	Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Иргэн, байгууллагуудын хандлага

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар
5	Практикт нийцэж байгаа байдал	Хуулийн зохицуулалт бодит нөхцөлд нийцэж байгаа эсэх

1.6 Мэдээлэл цуглуулах арга

Энэхүү үнэлгээг хийхдээ тоон болон чанарын мэдээллийн эх сурвалжийг ашигласан. Судалгаанд дараах мэдээлэл цуглуулах аргыг хэрэглэв.

- баримт бичгийн шинжилгээ
- статистик мэдээллийн шинжилгээ
- салбарын байгууллагын тайлан, мэдээлэл
- тохиолдол судлах арга
- олон улсын туршлагын харьцуулсан судалгаа

Мөн Ус сувгийн удирдах газар, Усны газар, салбарын статистик мэдээлэл, өмнөх судалгааны тайланг ашиглан салбарын бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийв.

Эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд салбарын статистик мэдээлэл, бодлогын баримт бичиг, байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, өмнөх судалгааны үр дүнг ашиглан үнэлгээ хийв.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1 Хот, суурины ус хангамжийн тогтолцоо

Монгол Улсад хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь олон шатлалт институцийн тогтолцоонд тулгуурлан хэрэгждэг. Энэхүү тогтолцоонд төрийн бодлого боловсруулах байгууллага, салбарын зохицуулах байгууллага, орон нутгийн захиргаа, ус хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд оролцдог.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиар салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүргийг төрийн байгууллагуудад хуваарилсан байдаг. Тухайлбал, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллага салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүргийг хэрэгжүүлдэг бол орон нутгийн захиргааны байгууллагууд тухайн нутаг дэвсгэрт ус хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийг хангах үүргийг гүйцэтгэдэг.

Нөгөө талаас ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2. Хот, суурины ус хангамжийн салбарын институцийн бүтэц

Байгууллага	Чиг үүрэг
Засгийн газар	Салбарын бодлого тодорхойлох
Төрийн захиргааны төв байгууллага	Салбарын бодлого хэрэгжүүлэх
Зохицуулах хороо	Тариф, тусгай зөвшөөрөл, зохицуулалт
Орон нутгийн захиргаа	Дэд бүтцийн хөгжил, үйлчилгээний зохион байгуулалт
Усны үйлчилгээний байгууллагууд	Ус хангамж, бохир усны үйлчилгээ

Энэхүү институцийн тогтолцоо нь салбарын үйл ажиллагааг зохицуулах үндсэн бүтэц болж байгаа боловч байгууллагуудын чиг үүргийн давхардал, уялдаа холбоо хангалтгүй байх зэрэг асуудлууд практикт ажиглагддаг.

2.2 Ус хангамжийн үйлчилгээний хүртээмж

Хот, суурины ус хангамжийн үйлчилгээ нь хүн амын амьдралын чанар, эрүүл ахуйн нөхцөлд шууд нөлөөлдөг чухал дэд бүтэц юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хотжилт эрчимтэй нэмэгдэж, хүн амын төвлөрөл томоохон хот, сууринд өсөхийн зэрэгцээ ус хангамжийн үйлчилгээний эрэлт нэмэгдэж байна.

Томоохон хот, сууринд төвлөрсөн ус хангамжийн систем хөгжсөн боловч зарим гэр хорооллын бүс болон жижиг суурин газруудад төвлөрсөн бус ус хангамжийн систем зонхилж байна. Энэ нь усны хүртээмжийн түвшин бүс нутгаас хамааран харилцан адилгүй байхад нөлөөлж байна.

Хүснэгт 3. Хотын усны хэрэглээний бүтэц

Усны хэрэглээ	Дундаж хувь
Унд, ахуйн хэрэглээ	55–60 %
Үйлдвэрлэлийн хэрэглээ	20–25 %
Нийтийн үйлчилгээ	10–15 %
Усны алдагдал	10–15 %

Эх сурвалж: Ус сувгийн удирдах газар?

Эндээс харахад унд, ахуйн хэрэглээ нийт усны хэрэглээний хамгийн их хувийг эзэлж байгаа боловч үйлдвэрлэлийн усны хэрэглээ нь усны нөөцөд үзүүлэх дарамтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

2.3 Хаягдал, бохир усны цэвэрлэгээ, менежментийн тогтолцоо

Хот, суурины усны хэрэглээнээс үүсч буй хаягдал бохир ус нь ариутгах татуургын системээр дамжин бохир усыг цэвэрлэх байгууламжид хүргэгдэж, цэвэрлэгээний технологийн процессоор боловсруулагддаг.

Монгол Улсын томоохон хот, сууринд бохир ус цэвэрлэх байгууламж ажиллаж байгаа боловч зарим байгууламжийн технологийн хүчин чадал өсөн нэмэгдэж буй ачааллыг бүрэн хангаж чадахгүй байгаа асуудал ажиглагдаж байна.

Мөн цэвэрлэсэн хаягдал усыг дахин ашиглах тогтолцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь усны нөөцийн ашиглалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

2.4 Салбарын хөгжлийн ерөнхий үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбар нь Монгол Улсын дэд бүтцийн хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүн амын амьдралын чанар, эрүүл ахуйн нөхцөл, байгаль орчны хамгаалалтай шууд холбоотой стратегийн ач холбогдолтой салбар юм. Сүүлийн жилүүдэд хотжилт, хүн амын төвлөрөл нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил өсөхийн зэрэгцээ ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний эрэлт нэмэгдсэн нь салбарын дэд бүтэц, үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх шаардлагыг улам нэмэгдүүлж байна.

Салбарын хөгжлийн явцад ус хангамжийн дэд бүтцийг өргөтгөх, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, усны үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд боловсронгуй болох зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байна. Ялангуяа томоохон хот, сууринд ус хангамжийн системийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийг шинэчлэх чиглэлээр тодорхой хөрөнгө оруулалт хийгдэж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээ хэрэгжиж байна.

Мөн салбарын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ (Хүснэгт №4) хийхэд шийдвэрлэх шаардлагатай хэд хэдэн асуудал байсаар байна.

Нэгдүгээрт, ус хангамжийн дэд бүтцийн зарим хэсэгт шугам сүлжээний элэгдэл өндөр байгаа нь усны алдагдал нэмэгдэх, үйлчилгээний найдвартай байдал буурахад нөлөөлж байна.

Хоёрдугаарт, бохир усны цэвэрлэгээний дараах усыг дахин ашиглах эрх зүйн болон технологийн зохицуулалт хангалтгүй байгаа нь усны нөөцийг үр ашигтай ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Гуравдугаарт, салбарын байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо, мэдээллийн нэгдсэн тогтолцоо хангалтгүй байгаа нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах нэг хүчин зүйл болж байна.

Дөрөвдүгээрт, ус хангамж, ариутгах татуургын системийг шинэчлэх, өргөтгөхөд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэр хязгаарлагдмал байгаа нь дэд бүтцийн хөгжилд тодорхой саад учруулж байна.


Хүснэгт 4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын SWOT шинжилгээ

Ангилал	Агуулга
	<ul style="list-style-type: none">• Салбарыг зохицуулах эрх зүйн үндсэн орчин бүрдсэн
Давуу тал	<ul style="list-style-type: none">• Томоохон хот, сууринд төвлөрсөн ус хангамжийн систем хөгжсөн• Бохир ус цэвэрлэх байгууламжийн үндсэн дэд бүтэц бий• Шугам сүлжээний элэгдэл, усны алдагдал өндөр
Сул тал	<ul style="list-style-type: none">• Бохир усны дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалт сул• Салбарын байгууллагуудын уялдаа, мэдээллийн нэгдсэн тогтолцоо хангалтгүй• Ус дахин ашиглах технологи нэвтрүүлэх боломж
Боломж	<ul style="list-style-type: none">• Олон улсын байгууллагын санхүүжилт, техникийн дэмжлэг• Усны нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх бодлогын орчин• Хотжилт, хүн амын өсөлтөөс үүдэлтэй усны эрэлт нэмэгдэх
Эрсдэл	<ul style="list-style-type: none">• Газрын доорх усны нөөцийн дарамт• Дэд бүтцийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгө оруулалт хангалтгүй байх

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын тогтвортой хөгжлийг хангахын тулд институцийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох, санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, дэд бүтцийн шинэчлэл, технологийн сайжруулалтыг дэмжих, бохир усны дахин ашиглалтын эрх зүйн орчныг хөгжүүлэх зэрэг бодлогын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зураг 3. Хот, суурины ус хангамжийн салбарын тулгамдсан асуудлын бүтэц



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1 Хуулийн зорилтын хэрэгжилтийн үнэлгээ

(1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт) Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилгыг “хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах” гэж тодорхойлсон байдаг.

Энэхүү зорилт нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах үндсэн зорилготой юм.

Хуулийн зорилтын хэрэгжилтийг үнэлэхдээ дараах үндсэн асуудлыг авч үзэв. Үүнд:

- хот, суурины ус хангамжийн үйлчилгээний хүртээмж
- бохир ус зайлуулах, цэвэрлэх системийн хөгжил
- усны үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалт
- усны нөөцийн тогтвортой ашиглалтын бодлогын хэрэгжилт

Хэрэгжилтийн байдал

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хот, суурины ус хангамжийн үйлчилгээний эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдэж, салбарын үйл ажиллагааг зохицуулах институцийн тогтолцоо бий болсон байна.

Монгол Улсад хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь төрийн бодлого боловсруулах байгууллага, салбарын зохицуулах байгууллага, орон нутгийн захиргаа, ус хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын оролцоонд тулгуурлан хэрэгжиж байна.

Усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, хот, суурины хэрэглэгчдийг унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усаар хангаж байна.

Сүүлийн жилүүдэд томоохон хот, суурин газруудад ус хангамжийн дэд бүтцийг өргөтгөх, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ хэрэгжсэн байна.

Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотод төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, ус хангамжийн шугам сүлжээний өргөтгөл хийх, шинэ хорооллуудыг төвлөрсөн ус хангамжийн системд холбох зэрэг төслүүд хэрэгжиж байгаа нь салбарын дэд бүтцийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Илэрч буй асуудал

Гэсэн хэдий ч хуулийн зорилго бүрэн хэмжээнд хэрэгжсэн гэж үзэхэд хүндрэлтэй байна.

Нэгдүгээрт, хотжилтын өсөлт, хүн амын төвлөрөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор усны хэрэглээ эрчимтэй өсөж байгаа нь ус хангамжийн системд ачаалал үүсгэж байна. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотын ус хангамжийн систем нь ихэвчлэн газрын доорх усны нөөцөд тулгуурладаг бөгөөд усны нөөцийн тогтвортой ашиглалттай холбоотой асуудал тулгарч байна.

Хоёрдугаарт, хот, суурины зарим бүс нутагт ус хангамжийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр байна. Тухайлбал, гэр хорооллын бүсийн оршин суугчдын ихэнх нь

төвлөрсөн ус хангамжийн системд холбогдоогүй бөгөөд зөөврийн ус, худгийн усыг ашиглах хэвээр байна.

Гуравдугаарт, бохир ус зайлуулах, цэвэрлэх дэд бүтцийн хүчин чадал зарим хот, сууринд хүрэлцэхгүй байгаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бий болгож байна. Зарим цэвэрлэх байгууламжийн технологийн шийдэл хуучирсан, ашиглалтын хугацаа дууссан байх тохиолдол ажиглагддаг.

Дөрөвдүгээрт, бохир усны цэвэрлэгээний дараах усыг дахин ашиглах тогтолцоо хангалттай хөгжөөгүй байна. Цэвэрлэгдсэн усыг үйлдвэрлэл, ногоон байгууламжийн усалгаа зэрэг зориулалтаар ашиглах боломж байгаа боловч холбогдох эрх зүйн зохицуулалт, стандарт, эдийн засгийн механизм бүрэн хөгжөөгүй хэвээр байна.

Үр дагавар

Дээрх нөхцөл байдлын улмаас хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын тогтвортой хөгжилд дараах сөрөг үр дагавар үүсэх эрсдэл ажиглагдаж байна.

- усны нөөцийн ашиглалтад үзүүлэх ачаалал нэмэгдэх
- бохир усны зохисгүй менежментээс үүдэлтэй байгаль орчны эрсдэл нэмэгдэх
- ус хангамжийн үйлчилгээний хүртээмжийн ялгаа нэмэгдэх
- салбарын дэд бүтцийн шинэчлэлийн хэрэгцээ өсөх

Эдгээр нөхцөл байдал нь хот, суурины ус хангамжийн системийн тогтвортой байдлыг хангах, усны нөөцийн хамгаалалтыг сайжруулах бодлогын арга хэмжээг цаашид эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн зорилт нь салбарын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд тодорхой хэмжээгээр хэрэгжсэн гэж үзэх боломжтой байна.

Гэсэн хэдий ч хотжилтын өсөлт, усны хэрэглээний нэмэгдэл, дэд бүтцийн хүчин чадлын хязгаар, бохир усны дахин ашиглалтын зохицуулалт сул зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр хуулийн зорилго бүрэн хэмжээнд хэрэгжсэн гэж дүгнэхэд хүндрэлтэй байна.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын эрх зүйн зохицуулалтыг салбарын хөгжлийн шинэ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, усны нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих, хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлага байгааг хэрэгжилтийн үнэлгээний үр дүн харуулж байна.

3.2 Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

(5, 6, 7 дугаар зүйл) Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тодорхойлсон байдаг.

Хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагуудын бүрэн эрхийг тогтоож, салбарын бодлогын удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

Энэхүү зохицуулалт нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын бодлогыг нэгдсэн удирдлагаар хангах, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, дэд бүтцийн хөгжлийг дэмжих зорилготой юм.

Хэрэгжилтийн байдал

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах үйл ажиллагаанд төрийн байгууллагууд тодорхой үүрэг гүйцэтгэж байна.

Засгийн газар нь салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрийг батлах, дэд бүтцийн томоохон төслийг хэрэгжүүлэх, салбарын хөгжлийг дэмжих санхүүжилтийн бодлогыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Төрийн захиргааны төв байгууллага нь салбарын бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, стандарт, норм, дүрэм боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Орон нутгийн захиргааны байгууллагууд нь тухайн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний хүртээмжийг хангах, дэд бүтцийн хөгжлийг дэмжих, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үндсэн тогтолцоо бүрдэж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр зохион байгуулагдаж байна.

Илэрч буй асуудал

Хэдийгээр төрийн байгууллагуудын бүрэн эрхийг хуульд тодорхойлсон боловч практикт дараах хүндрэл, бэрхшээл тулгарч байна.

Нэгдүгээрт, салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо хангалтгүй байна. Усны нөөцийн менежмент, ус хангамжийн үйлчилгээ, хаягдал бохир усны менежмент зэрэг асуудал нь хэд хэдэн байгууллагын чиг үүрэгт хамаарах бөгөөд байгууллагуудын хоорондын зохицуулалт зарим тохиолдолд тодорхой бус байна.

Хоёрдугаарт, салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоо хангалттай хөгжөөгүй байна. Ус хангамжийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, усны хэрэглээ, бохир усны хэмжээ, дэд бүтцийн ашиглалтын талаарх мэдээлэл нэгдсэн системд бүрэн төвлөрдөггүй тул

бодлого боловсруулах, төлөвлөх үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийн хүртээмж хязгаарлагдмал байдаг.

Гуравдугаарт, орон нутгийн түвшинд ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, техник, технологийн чадавх зарим тохиолдолд хангалтгүй байна. Энэ нь салбарын бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах нөхцөл болдог.

Дөрөвдүгээрт, салбарын бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байгаа нь бодлогын хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, сайжруулахад хүндрэл учруулж байна.

Үр дагавар

Дээр дурдсан нөхцөл байдлын улмаас салбарын бодлогын хэрэгжилтэд дараах үр дагавар ажиглагдаж байна.

- байгууллагуудын чиг үүргийн давхардал, уялдаа сул байх
- бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагаа удаашрах
- салбарын мэдээллийн хүртээмж хязгаарлагдах
- орон нутгийн түвшинд дэд бүтцийн хөгжлийн ялгаа үүсэх

Эдгээр нөхцөл байдал нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тогтвортой хөгжлийг хангахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тодорхойлсон зохицуулалт нь салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх институцийн үндсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Гэвч салбарын бодлого хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, бодлогын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний механизм хангалттай хөгжөөгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна.

Иймд салбарын бодлого хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох шаардлага байгааг хэрэгжилтийн үнэлгээний үр дүн харуулж байна.

Хүснэгт 6. Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт

Үнэлгээ

Зохицуулалтын тодорхой байдал

Дунд

Үзүүлэлт	Үнэлгээ
Байгууллагуудын уялдаа холбоо	Сул
Бодлогын хэрэгжилтийн үр нөлөө	Дунд
Мэдээллийн нэгдсэн тогтолцоо	Сул

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

3.3 Ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

(10–16 дугаар зүйл) Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, эрх үүрэг, хэрэглэгчтэй харилцах харилцаа, үйлчилгээний нөхцөл, стандарттай холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг.

Хуулийн 10–16 дугаар зүйлд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх нөхцөл, хэрэглэгчийн эрх, үүрэг, гэрээний харилцааг тодорхойлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон байна.

Энэхүү зохицуулалтын зорилго нь хот, суурины хэрэглэгчдийг найдвартай, тасралтгүй ус хангамжийн үйлчилгээ болон ариутгах татуургын үйлчилгээ авах нөхцөлөөр хангах, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааг тодорхой стандарт, шаардлагын хүрээнд зохион байгуулахад оршино.

Хэрэгжилтийн байдал

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаар дамжин хэрэгжиж байна.

Усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэглэгчдийг унд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усаар хангах үндсэн үүргийг хэрэгжүүлдэг.

Томоохон хот, суурин газруудад ус хангамжийн үйлчилгээ нь төвлөрсөн шугам сүлжээнд суурилсан системээр хэрэгждэг бөгөөд хэрэглэгчид ус хангамжийн байгууллагатай гэрээ байгуулан үйлчилгээ авдаг тогтолцоо бүрдсэн байна.

Мөн ус хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа, усны чанарын хяналт, хэрэглэгчийн үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Үүнээс гадна ус хангамжийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд холбогдох стандарт, техникийн шаардлага, ашиглалтын дүрэм, тарифын зохицуулалт зэрэг зохицуулалт үйлчилж байгаа нь салбарын үйл ажиллагааг тодорхой хэмжээнд тогтворжуулахад нөлөөлж байна.

Илэрч буй асуудал

Хэдийгээр ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн боловч практикт дараах хүндрэл, бэрхшээл ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, ус хангамжийн инженерийн шугам сүлжээний зарим хэсэгт элэгдэл, ашиглалтын хугацаа дууссан асуудал түгээмэл байна. Зарим хот, сууринд шугам сүлжээний элэгдэл 40–60 хувьд хүрсэн талаар салбарын судалгаанд дурдагддаг. Энэ нь усны алдагдал нэмэгдэх, үйлчилгээний найдвартай байдал буурах эрсдэлийг бий болгодог.

Хоёрдугаарт, ус хангамжийн үйлчилгээний байгууллагын санхүүгийн тогтвортой байдал зарим тохиолдолд хангалтгүй байна. Усны үйлчилгээний тариф нь зарим хот, сууринд үйлчилгээний бодит өртгийг бүрэн нөхөхгүй байх тохиолдол ажиглагддаг бөгөөд энэ нь дэд бүтцийн засвар шинэчлэлд шаардагдах хөрөнгө оруулалтыг хязгаарлах нөхцөл болдог.

Гуравдугаарт, хэрэглэгчийн үйлчилгээтэй холбоотой зарим асуудал ажиглагддаг. Тухайлбал, усны тасалдал, даралт буурах, инженерийн шугам сүлжээний гэмтэл зэрэг асуудал гарсан үед мэдээлэл солилцох, шуурхай арга хэмжээ авах тогтолцоо зарим хот, сууринд хангалттай хөгжөөгүй байна.

Дөрөвдүгээрт, ус хангамжийн үйлчилгээний байгууллагуудын технологийн шинэчлэл, тоног төхөөрөмжийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр байгаа боловч санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал байна.

Үр дагавар

Дээрх нөхцөл байдлын улмаас ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд дараах үр дагавар ажиглагдаж байна.

- ус хангамжийн шугам сүлжээний алдагдал нэмэгдэх
- үйлчилгээний тасалдал, найдвартай байдлын асуудал үүсэх
- дэд бүтцийн шинэчлэл удаашрах
- үйлчилгээний байгууллагын санхүүгийн ачаалал нэмэгдэх

Эдгээр нөхцөл байдал нь хот, суурины ус хангамжийн үйлчилгээний чанар, хүртээмжид тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэс тодорхой хэмжээгээр бүрдсэн байна.

Гэсэн хэдий ч инженерийн шугам сүлжээний элэгдэл, санхүүжилтийн хүндрэл, технологийн шинэчлэлийн хэрэгцээ зэрэг хүчин зүйлс нь үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд тодорхой бэрхшээл учруулж байна.

Иймд ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг дэмжих санхүүгийн механизм бий болгох, инженерийн шугам сүлжээний шинэчлэлийг эрчимжүүлэх, хэрэглэгчийн үйлчилгээний чанарыг сайжруулах бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байгааг хэрэгжилтийн үнэлгээний үр дүн харуулж байна.

Хүснэгт 7. Ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ
Зохицуулалтын тодорхой байдал	Дунд
Үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа	Дунд
Санхүүгийн тогтвортой байдал	Сул
Инженерийн шугам сүлжээний байдал	Сул
Хэрэглэгчийн үйлчилгээ	Дунд

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

3.4 Бохир ус зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

(17–21 дүгээр зүйл) Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд бохир ус татан зайлуулах, цэвэрлэх, ариутгах татуургын системийн ашиглалттай холбоотой харилцааг зохицуулах зохицуулалтыг тусгасан байдаг.

Хуулийн 17–21 дүгээр зүйлд бохир усны шугам сүлжээний ашиглалт, бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, ариутгах татуургын системийн ашиглалтын нөхцөл, бохир ус цэвэрлэхтэй холбоотой техникийн шаардлага зэрэг асуудлыг зохицуулсан байна.

Энэхүү зохицуулалтын зорилго нь хот, суурины хэрэглээнээс гарч буй бохир усыг төвлөрсөн системээр татан зайлуулах, цэвэрлэх байгууламжид хүргэх, улмаар байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэхгүйгээр боловсруулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хэрэгжилтийн байдал

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын хот, суурины ихэнх хэсэгт төвлөрсөн ариутгах татуургын систем тодорхой хэмжээнд хөгжсөн байна.

Томоохон хот, суурин газруудад бохир ус татан зайлуулах шугам сүлжээ, насос станц, бохир ус цэвэрлэх байгууламж бүхий систем ажиллаж байгаа бөгөөд хэрэглэгчдээс гарсан бохир усыг төвлөрсөн байдлаар татан зайлуулах тогтолцоо бүрдсэн байна.

Ялангуяа нийслэл Улаанбаатар хотод бохир ус цэвэрлэх төвлөрсөн байгууламж ажиллаж, хотын бохир усны ихэнх хэсгийг боловсруулж байна. Сүүлийн жилүүдэд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн нь салбарын дэд бүтцийн шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Үүнээс гадна зарим аймаг, хотод бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих, шинэчлэх, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөх ажил үе шаттайгаар хэрэгжиж байна.

Илэрч буй асуудал

Гэсэн хэдий ч бохир ус зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтэд дараах хүндрэл, бэрхшээл ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, ариутгах татуургын шугам сүлжээний хамрах хүрээ зарим хот, сууринд хангалтгүй байна. Ялангуяа гэр хорооллын бүсийн айл өрхүүд төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдоогүй байгаа нь бохир усны зохистой менежментэд хүндрэл учруулж байна.

Хоёрдугаарт, зарим бохир ус цэвэрлэх байгууламжийн технологи хуучирсан, ашиглалтын хугацаа дууссан асуудал ажиглагдаж байна. Үүний улмаас бохир усны цэвэрлэгээний үр ашиг буурах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэх эрсдэл нэмэгдэх нөхцөл бий болдог.

Гуравдугаарт, бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын зардал өндөр байдаг. Эрчим хүчний хэрэглээ, химийн бодисын хэрэглээ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ зэрэг зардал өндөр байгаагаас шалтгаалан зарим байгууламжийн үйл ажиллагаа санхүүгийн хүндрэлтэй тулгардаг.

Дөрөвдүгээрт, бохир усны цэвэрлэгээний дараах усыг дахин ашиглах эрх зүйн зохицуулалт хангалттай хөгжөөгүй байна. Цэвэрлэгдсэн усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, ногоон байгууламж услах, технологийн ус болгон ашиглах боломж байгаа боловч холбогдох стандарт, зохицуулалт тодорхой бус хэвээр байна.

Үр дагавар

Дээрх нөхцөл байдлын улмаас бохир усны менежментэд дараах сөрөг үр дагавар үүсэх эрсдэл ажиглагдаж байна.

- бохир ус цэвэрлэх байгууламжийн ачаалал нэмэгдэх
- байгаль орчны бохирдлын эрсдэл нэмэгдэх
- усны нөөцийн ашиглалтын үр ашиг буурах

- цэвэрлэгдсэн усны боломжит нөөц ашиглагдахгүй үлдэх

Эдгээр нөхцөл байдал нь усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах, хотын усны менежментийг сайжруулахад сөргөөр нөлөөлж байна.

Дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн бохир ус зайлуулах, цэвэрлэхтэй холбоотой зохицуулалт нь салбарын үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Гэсэн хэдий ч ариутгах татуургын шугам сүлжээний хамрах хүрээ, цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл, санхүүжилтийн асуудал, бохир усны дахин ашиглалтын зохицуулалт зэрэг асуудал нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна.

Иймд бохир усны менежментийг сайжруулах, цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэлийг дэмжих, бохир усны дахин ашиглалтыг эрх зүйн хүрээнд тодорхой зохицуулах шаардлага байгааг хэрэгжилтийн үнэлгээний үр дүн харуулж байна.

Хүснэгт 8. Бохир ус зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ
Зохицуулалтын тодорхой байдал	Дунд
Ариутгах татуургын шугам сүлжээний хамрах хүрээ	Дунд
Бохир ус цэвэрлэх технологийн байдал	Сул
Санхүүгийн тогтвортой байдал	Сул
Дахин ашиглалтын боломж	Сул

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

3.5 Хяналт, хариуцлагын зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

(22–23 дугаар зүйл) Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд салбарын үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог тодорхойлсон зохицуулалтыг тусгасан байдаг.

Хуулийн 22 болон 23 дугаар зүйлд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын үндсийг тогтоосон байна.

Энэхүү зохицуулалтын зорилго нь хот, суурины ус хангамжийн үйлчилгээний чанар, найдвартай байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад оршино.

Хэрэгжилтийн байдал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын үйл ажиллагаанд төрийн хяналт шалгалтын байгууллагууд болон холбогдох төрийн байгууллагууд тодорхой чиг үүргийн хүрээнд хяналт тавьж байна.

Хяналтын үйл ажиллагаанд дараах чиглэлүүд хамрагддаг.

- ус хангамжийн үйлчилгээний чанар
- усны эх үүсвэрийн хамгаалалт
- бохир ус цэвэрлэх байгууламжийн ажиллагаа
- ариутгах татуургын системийн ашиглалт
- усны чанарын стандартын хэрэгжилт

Эдгээр чиглэлээр салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Мөн байгаль орчны хяналтын байгууллагууд бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, усны бохирдлын түвшинд хяналт тавьж, холбогдох шаардлагыг хүргүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэг.

Илэрч буй асуудал

Хяналтын тогтолцоо хуульд тодорхойлогдсон боловч практикт зарим хүндрэл ажиглагддаг.

Нэгдүгээрт, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо зарим тохиолдолд хангалтгүй байдаг. Усны нөөцийн хамгаалалт, бохир усны менежмент, ус хангамжийн үйлчилгээ зэрэг асуудал хэд хэдэн байгууллагын чиг үүрэгт хамрагддаг тул хяналтын үйл ажиллагаанд давхардал, зохицуулалтын сул тал илэрдэг.

Хоёрдугаарт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах техник, технологийн боломж зарим тохиолдолд хязгаарлагдмал байдаг. Усны чанарын хяналт, бохир усны найрлагын шинжилгээ зэрэг ажиллагаанд орчин үеийн тоног төхөөрөмж, лабораторийн чадавх шаардлагатай байдаг.

Гуравдугаарт, хууль тогтоомжийн зөрчилд ногдуулах хариуцлагын механизм практикт төдийлөн үр нөлөөтэй хэрэгжихгүй байх тохиолдол ажиглагддаг. Зарим тохиолдолд зөрчлийг арилгах хугацаа удаашрах, хяналтын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл бий болдог.

Дөрөвдүгээрт, салбарын үйл ажиллагаанд тавих хяналтын мэдээллийн нэгдсэн систем бүрэн хөгжөөгүй байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулах нөхцөл болдог.

Үр дагавар

Дээр дурдсан нөхцөл байдлын улмаас салбарын үйл ажиллагаанд дараах үр дагавар илэрч байна.

- хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд давхардал үүсэх
- хяналтын арга хэмжээний үр нөлөө буурах
- зөрчил арилгах ажиллагаа удаашрах
- байгаль орчны эрсдэл нэмэгдэх боломж үүсэх

Эдгээр нөхцөл байдал нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд салбарын үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын зохицуулалт тодорхой хэмжээгээр бүрдсэн байна.

Салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг илрүүлэх, шаардлагатай арга хэмжээ авах тогтолцоо хэрэгжиж байгаа боловч хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, техник технологийн чадавх, мэдээллийн нэгдсэн тогтолцоог цаашид сайжруулах шаардлага байна.

Иймд салбарын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хяналтын үйл ажиллагаанд орчин үеийн технологи нэвтрүүлэх, зөрчилд хүлээлгэх хариуцлагын механизмыг илүү үр нөлөөтэй болгох чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хүснэгт 9. Хяналт, хариуцлагын зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ
Зохицуулалтын тодорхой байдал	Дунд
Хяналтын байгууллагын үйл ажиллагаа	Дунд
Хяналтын үр нөлөө	Сул
Хариуцлагын механизм	Сул
Мэдээллийн тогтолцоо	Сул

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

3.6 Хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ хуулийн үндсэн зохицуулалтуудын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийн түвшин, тулгамдсан асуудал, үүсэж буй үр дагаврыг дараах байдлаар тодорхойлов.

Энэхүү нэгдсэн үнэлгээ нь хуулийн хэрэгжилтийн бодит нөхцөл байдлыг цогцоор нь харуулах, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлийг тодорхойлоход чиглэж байна.

Хүснэгт 10. Хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ

Хуулийн зохицуулалт	Хэрэгжилтийн түвшин	Илэрч буй асуудал	Үүсэж буй үр дагавар
Хуулийн бодлогын зохицуулалт	зорилт, Дунд	Хотжилт, хэрэглээний өсөлт	усны Усны нөөцийн ачаалал нэмэгдэх
Төрийн бүрэн эрх	байгууллагын Дунд	Байгууллагуудын сул	уялдаа Бодлогын хэрэгжилт удаашрах
Ус үйлчилгээний байгууллагын ажиллагаа	хангамжийн үйл Дунд	Шугам элэгдэл, хүндрэл	сүлжээний Үйлчилгээний санхүүгийн найдвартай байдал буурах
Ариутгах систем	татуургын Дунд	Шугам сүлжээний хүрээ хангалтгүй	хамрах Бохир усны зохисгүй менежмент
Бохир ус ажиллагаа	цэвэрлэх үйл Сул	Технологийн хоцрогдол	Байгаль орчны эрсдэл нэмэгдэх
Бохир ус ашиглалт	усны дахин Сул	Эрх зүйн зохицуулалт тодорхой бус	Усны нөөцийн үр ашиг буурах
Хяналт, тогтолцоо	хариуцлагын Дунд	Хяналтын уялдаа сул	Хяналтын үр нөлөө буурах

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

Нэгдсэн үнэлгээ

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг нэгтгэн дүгнэхэд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн гэж үзэх боломжтой. Салбарын үйлчилгээний тогтолцоо, байгууллагын бүтэц, үйлчилгээний үндсэн үйл ажиллагаа тодорхой хэмжээнд тогтворжсон байна.

Нөгөө талаар хотжилтын өсөлт, усны хэрэглээний нэмэгдэл, инженерийн шугам сүлжээний элэгдэл, бохир ус цэвэрлэх технологийн хоцрогдол зэрэг хүчин зүйлс салбарын хөгжлийн шинэ шаардлагыг бий болгож байна.

Мөн бохир усны дахин ашиглалтын зохицуулалт тодорхой бус, усны нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих бодлогын зохицуулалт хангалттай хөгжөөгүй зэрэг асуудал ажиглагдаж байна.

Ийм нөхцөл байдал нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын эрх зүйн зохицуулалтыг салбарын хөгжлийн шинэ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

3.7 Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах үйл ажиллагаанд оролцох төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тодорхойлж, институцийн тогтолцооны үндсийг тогтоосон байдаг. Тус хуулийн холбогдох зүйл, заалтаар Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, зохицуулах байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг ялган тодорхойлсон.

Хуулийн дагуу Засгийн газар нь салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох, төрийн захиргааны төв байгууллага нь ус хангамж, ариутгах татуургын салбарын бодлогыг хэрэгжүүлэх, салбарын үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Харин орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь тухайн нутаг дэвсгэрт ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөгжлийг дэмжих, салбарын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах үүргийг хүлээдэг.

Хуулийн дээрх зохицуулалт нь салбарын институцийн тогтолцоог бүрдүүлж, төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой хэмжээнд ялган зааглах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд ус хангамж, ариутгах татуургын салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах үйл ажиллагаанд оролцох байгууллагуудын үндсэн чиг үүрэг тодорхой болсон гэж дүгнэв.

Гэсэн хэдий ч хуулийн хэрэгжилтийн бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд төрийн байгууллагуудын хоорондын чиг үүргийн уялдаа холбоо хангалттай түвшинд хэрэгжихгүй байх тохиолдол ажиглагдаж байна. Ялангуяа салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа сул байх, мэдээллийн солилцоо, хамтын ажиллагааны механизм хангалттай хөгжөөгүй байх зэрэг асуудал илэрч байна. Үүний улмаас салбарын бодлогын хэрэгжилт зарим тохиолдолд удаашрах, шийдвэр гаргалт удаашрах нөхцөл бүрдсэн байгаа нь илэрхий болов.

Мөн салбарын хэмжээнд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний талаарх мэдээллийн нэгдсэн систем бүрэн хөгжөөгүй байгаа нь бодлогын шийдвэр гаргах, салбарын үйл ажиллагааг төлөвлөх, хяналт тавих үйл ажиллагаанд тодорхой хүндрэл үүсгэж байна. Энэ нь

төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын бодлого хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах, байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгох, салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх чухал нөхцөл болох нь хэрэгжилтийн үнэлгээний үр дүнгээс харагдаж байна.

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэхэд төрийн байгууллагуудын бүрэн эрхийн зохицуулалтын тодорхой байдал харьцангуй хангалттай боловч байгууллагуудын уялдаа холбоо, мэдээллийн нэгдсэн тогтолцоо хангалтгүй байгаа нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөөнд нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын бүрэн эрхийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ
Зохицуулалтын тодорхой байдал	Дунд
Байгууллагуудын уялдаа холбоо	Сул
Бодлогын хэрэгжилтийн үр нөлөө	Дунд
Мэдээллийн нэгдсэн тогтолцоо	Сул

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

3.8 Ус хангамжийн үйлчилгээний зохицуулалтын хэрэгжилт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан ундны болон ахуйн хэрэглээний усаар хангах, ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг тогтоосон. Тус хуулийн зохицуулалтаар ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа болон хэрэглэгчдэд үзүүлэх ус хангамжийн үйлчилгээний үндсэн шаардлагыг тодорхойлсон байдаг.

Хуулийн хэрэгжилтийн хугацаанд томоохон хот, суурин газруудад төвлөрсөн ус хангамжийн системийн хөгжил тодорхой хэмжээнд ахиж, ус хангамжийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх хандлага ажиглагдав. Ялангуяа нийслэл болон аймгийн төвүүдэд ус хангамжийн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэл хийгдэж, хэрэглэгчдийг төвлөрсөн ус хангамжийн системд холбох боломж нэмэгдсэн гэж дүгнэж болно.

Зураг 4. Хотын ус хангамж, ариутгах татуургын системийн ерөнхий бүтэц



Салбарын бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд ус хангамжийн дэд бүтцийн зарим хэсэгт шугам сүлжээний элэгдэл өндөр хэвээр байгаа нь усны алдагдал нэмэгдэх, үйлчилгээний найдвартай байдал буурахад нөлөөлөх эрсдэлтэй. Мөн зарим хот, сууринд ус хангамжийн системийн хүчин чадал өсөн нэмэгдэж буй усны хэрэглээг бүрэн хангахгүй байх тохиолдол ажиглагдав.

Үүнээс гадна ус хангамжийн үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо нь зарим нөхцөлд бодит өртгийг бүрэн тусгахгүй байх асуудал илэрч байна. Тарифын зохицуулалт үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг бүрэн нөхөхгүй байх тохиолдол гардаг нь дэд бүтцийн шинэчлэл, засвар үйлчилгээ, технологийн сайжруулалтад шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрдүүлэхэд хүндрэл үүсгэх хүчин зүйл болж байна.

Иймд ус хангамжийн үйлчилгээний тогтолцоог тогтвортой хөгжүүлэхийн тулд дэд бүтцийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх, усны алдагдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх, тарифын зохицуулалтыг бодит өртөгт тулгуурлан сайжруулах шаардлагатай гэж үзэв. Эдгээр арга хэмжээ нь ус хангамжийн үйлчилгээний үр ашиг, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хүснэгт 6. Ус хангамжийн үйлчилгээний зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ
Ус хангамжийн үйлчилгээний хүртээмж	Дунд
Дэд бүтцийн найдвартай байдал	Дунд
Усны алдагдлын түвшин	Сул
Санхүүжилтийн тогтолцоо	Дунд

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

3.9 Бохир усны менежментийн зохицуулалтын хэрэгжилт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд бохир ус татан зайлуулах, цэвэрлэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй болгож цэвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг тогтоосон. Тус хуулийн хүрээнд хот, суурины ариутгах татуургын системийн үйл ажиллагааг зохион байгуулах, бохир усыг цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэрлэх, байгаль орчныг хамгаалах шаардлагыг хангах зохицуулалтыг тусгасан байдаг.

Хуулийн хэрэгжилтийн хугацаанд Монгол Улсын томоохон хот, сууринд бохир ус цэвэрлэх байгууламжийн тогтолцоо тодорхой хэмжээнд бүрэлдэж, ариутгах татуургын системээр дамжуулан бохир усыг төвлөрсөн байдлаар цэвэрлэх механизм бүрдсэн гэж дүгнэж болно. Ялангуяа нийслэл Улаанбаатар хотод бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх чиглэлээр тодорхой хөрөнгө оруулалт хэрэгжиж, бохир усыг цэвэрлэх системийн үр ашиг тодорхой хэмжээнд сайжирсан.

Гэсэн хэдий ч бохир усны менежментийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд хэд хэдэн асуудал тулгамдаж байна. Нэгдүгээрт, зарим хот, сууринд бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал өсөн нэмэгдэж буй бохир усны хэмжээг бүрэн цэвэрлэхэд хүрэлцэхгүй байх тохиолдол ажиглагдав. Хоёрдугаарт, бохир ус цэвэрлэгээний дараа усыг дахин ашиглах эрх зүйн болон техникийн зохицуулалт хангалттай хөгжөөгүй байгаа нь усны нөөцийг үр ашигтай ашиглах боломжид саад болж байна. Гуравдугаарт, хаягдал усны менежменттэй холбоотой стандарт, технологийн шаардлага зарим тохиолдолд орчин үеийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэхгүй байх асуудал ажиглагдав.

Мөн хаягдал усыг цэвэрлэсний дараа үйлдвэрлэл, ногоон байгууламжийн усалгаа, техникийн зориулалтаар ашиглах боломж тодорхой хэмжээнд байгаа боловч энэ чиглэлд нэгдсэн бодлого, зохицуулалтын механизм байхгүй байна. Үүний улмаас цэвэрлэсэн хаягдал усыг байгальд шууд хаях нөхцөл үүсч байгаа нь усны нөөцийн үр ашигтай ашиглалтад сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Иймд хаягдал усны менежментийн тогтолцоог боловсронгуй болгохын тулд цэвэрлэх, дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох стандарт, техникийн шаардлагыг шинэчлэх, бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, технологийн түвшинг үе шаттай сайжруулах шаардлагатай гэж дүгнэв. Энэ нь усны нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих, салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах бодлогын чухал чиглэл болно.

Хүснэгт 7. Бохир усны менежментийн зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ

Үзүүлэлт	Үнэлгээ
Бохир ус цэвэрлэх дэд бүтцийн хөгжил	Дунд
Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал	Дунд
Бохир ус дахин ашиглах зохицуулалт	Сул
Технологи, стандартын шинэчлэл	Дунд

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН НАРИЙВЧИЛСАН ШИНЖИЛГЭЭ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлох зорилгоор эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон институцийн үр нөлөөний чиглэлээр дүн шинжилгээ хийв.

4.1 Эдийн засгийн үр дагавар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль хэрэгжиж эхэлснээр ус хангамж, бохир усны үйлчилгээний салбарт тодорхой институцийн болон эдийн засгийн тогтолцоо бүрдсэн. Усны үйлчилгээний тариф тогтоох, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэс бий болсон нь салбарын үйл ажиллагааг илүү зохион байгуулалттай болгоход эерэг нөлөө үзүүлсэн.

Салбарын эдийн засгийн тогтвортой байдлын хүрээнд дараах асуудлууд ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, усны үйлчилгээний тариф нь ихэнх тохиолдолд бодит өртгийг бүрэн тусгаж чаддаггүй. Үүний улмаас ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны зардал бүрэн нөхөгдөхгүй, санхүүгийн хүндрэл үүсэх нөхцөл бүрдэж байна.

Хоёрдугаарт, ус хангамжийн дэд бүтцийг шинэчлэх, өргөтгөхөд шаардагдах хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь системийн техник, технологийн шинэчлэлийг удаашруулах шалтгаан болж байна.

Гуравдугаарт, бохир усны дахин ашиглалт хангалттай хөгжөөгүй байгаа нь усны нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглахгүй байх нөхцөл болж байна.

Эдгээр нөхцөл байдлын улмаас ус хангамж, ариутгах татуургын салбарын эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр тарифын бодлого, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлага байна.

4.2 Нийгмийн үр дагавар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль хэрэгжсэнээр хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах нөхцөл тодорхой хэмжээнд сайжирсан. Томоохон хот, суурин газруудад төвлөрсөн ус хангамжийн систем өргөжин хөгжиж, усны үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

Нөгөө талаар хотжилт эрчимтэй нэмэгдэж, хүн амын төвлөрөл ихсэж байгаатай холбоотойгоор ус хангамжийн үйлчилгээний ачаалал нэмэгдэж байна. Зарим гэр хорооллын

бүсэд төвлөрсөн ус хангамжийн систем бүрэн хүрэлцэхгүй байгаа нь усны хүртээмжийн асуудал үүсэхэд нөлөөлж байна.

Түүнчлэн ариун цэврийн байгууламжийн стандарт, бохир ус зайлуулах системийн хүртээмж хангалтгүй байгаа нь зарим бүс нутагт эрүүл ахуйн эрсдэл үүсэх нөхцөл болж байна.

Иймд ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийг өргөжүүлэх, гэр хорооллын бүсийн ус хангамж, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.3 Байгаль орчны үр дагавар

Хот, суурины ус хангамжийн систем нь үндсэндээ газрын доорх усны нөөцөд тулгуурладаг бөгөөд усны хэрэглээ ашиглалт нэмэгдэхийн хэрээр газрын доорх усны нөөцөд үзүүлэх ачаалал нэмэгдэж байна.

Ялангуяа Улаанбаатар хотын ус хангамжийн систем нь Туул голын сав газрын газрын доорх усны нөөцөөс ихээхэн хамааралтай байдаг. Усны хэрэглээ цаашид өсөх тохиолдолд усны нөөцийн тогтвортой байдлыг хангах асуудал илүү чухал болох төлөвтэй байна.

Нөгөө талаар бохир усны цэвэрлэгээний системийн хүчин чадал, технологийн түвшин нь зарим тохиолдолд өсөн нэмэгдэж буй ачааллыг бүрэн хангаж чадахгүй байгаа нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Цэвэрлэгдсэн бохир усыг дахин ашиглах тогтолцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь усны нөөцийг илүү үр ашигтай ашиглах боломжийг хязгаарлаж байна.

Иймд усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах, бохир усны цэвэрлэгээний технологийг сайжруулах, дахин ашиглах бодлогыг хөгжүүлэх шаардлагатай байна.

4.4 Институцийн үр дагавар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь салбарын институцийн зохицуулалтыг тодорхой хэмжээнд бүрдүүлсэн. Төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тодорхойлж, салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх бүтэц бий болсон.

Институцийн зохион байгуулалтын хүрээнд дараах асуудлууд ажиглагдаж байна.

- салбарын байгууллагуудын чиг үүргийн давхардал
- байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй
- мэдээллийн нэгдсэн тогтолцоо сул

Эдгээр нөхцөл байдал нь салбарын бодлого хэрэгжүүлэх явцад зохион байгуулалтын хүндрэл үүсгэж, шийдвэр гаргалтыг удаашруулах эрсдэлтэй байна.

Иймд салбарын институцийн зохион байгуулалтыг илүү оновчтой болгох, байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх шаардлагатай байна.

4.5 Нэгдсэн үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль хэрэгжсэнээр салбарын үндсэн эрх зүйн зохицуулалт бүрдсэн боловч хотжилт, усны хэрэглээний өсөлт, усны нөөцийн хомсдол зэрэг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох шаардлага байна.

Ялангуяа дараах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

- усны нөөцийн тогтвортой менежмент
- хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглалт
- салбарын санхүүжилтийн тогтолцоо
- институцийн зохицуулалт

4.6 Урьдчилан тооцоогүй үр дагавар

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль хэрэгжсэнээр урьдчилан тооцоогүй зарим үр дагавар ажиглагдсан. Үүнд хотжилтын өсөлт, усны хэрэглээний нэмэгдэлтэй холбоотойгоор ус хангамжийн системийн ачаалал нэмэгдэх, бохир усны менежментийн системийн хүчин чадалд дарамт үүсэх зэрэг нөхцөл байдал багтаж байна.

Мөн бохир ус дахин ашиглах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь усны нөөцийн үр ашигтай ашиглалтад нөлөөлж буй хүчин зүйл болж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ШААРДАГДАЖ БУЙ ЗОХИЦУУЛАЛТЫН НАРИЙВЧИЛСАН ШИНЖИЛГЭЭ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний хүрээнд хуулийн зарим зохицуулалт практикт хэрэгжих явцад хүндрэл үүсгэж байгаа нь тогтоогдсон. Үүнд эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, институцийн зохицуулалтын давхардал, салбарын хөгжлийн шинэ шаардлагад нийцээгүй зохицуулалт зэрэг асуудлууд багтаж байна.

5.1 Хуулийн зорилт ба бодлогын хүрээний зохицуулалтын асуудал

Хуулийн 1 дүгээр зүйлд хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилтыг тодорхойлсон байдаг.

Салбарын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулахад хуулийн зорилтын хүрээнд дараах асуудлууд илэрч байна.

Илэрч буй асуудал

Нэгдүгээрт, усны нөөцийн тогтвортой ашиглалт болон усны эрэлт, нийлүүлэлтийн урт хугацааны менежментийн асуудал хуулийн зорилтын хүрээнд хангалттай тусгагдаагүй байна.

Хоёрдугаарт, бохир усны дахин ашиглалт, усны эргүүлэн ашиглах тогтолцоог хөгжүүлэх бодлогын зохицуулалт хангалттай тодорхой биш байна.

Үр дагавар

Эдгээр нөхцөл байдлын улмаас усны нөөцийн үр ашигтай ашиглалт, усны хэрэглээний тогтвортой байдлыг хангах бодлогын зохицуулалт сул байна.

Өөрчлөх шаардлага

Иймд хуулийн зорилтыг усны нөөцийн тогтвортой ашиглалт, бохир усны дахин ашиглалт, усны хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын чиглэлтэй уялдуулан өргөжүүлэх шаардлагатай байна.

5.2 Институцийн зохицуулалтын асуудал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарт төрийн байгууллагуудын бүрэн эрхийг хуульд тодорхойлсон боловч практикт дараах институцийн асуудлууд ажиглагдаж байна.

Илэрч буй асуудал

- салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн давхардал
- байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй
- мэдээллийн нэгдсэн тогтолцоо сул

Үр дагавар

Эдгээр асуудлын улмаас салбарын бодлого хэрэгжүүлэх явцад зохион байгуулалтын хүндрэл үүсч, зарим тохиолдолд шийдвэр гаргалт удаашрах нөхцөл бүрдэж байна.

Өөрчлөх шаардлага

Салбарын институцийн зохицуулалтыг илүү тодорхой болгох, байгууллагуудын чиг үүргийг оновчтой хуваарилах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

5.3 Тарифын зохицуулалтын асуудал

Усны үйлчилгээний тариф нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний санхүүгийн тогтвортой байдлыг хангах чухал механизм юм.

Илэрч буй асуудал

- тариф бодит өртгийг бүрэн тусгадаггүй
- үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны зардал бүрэн нөхөгдөхгүй байна
- дэд бүтцийн хөрөнгө оруулалт хангалтгүй байна

Үр дагавар

Эдгээр нөхцөл байдлын улмаас ус хангамжийн системийн шинэчлэл, өргөтгөлийн ажлыг санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж байна.

Өөрчлөх шаардлага

Усны үйлчилгээний тарифыг бодит өртөгт тулгуурлан тогтоох, салбарын санхүүжилтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

5.4 Бохир усны дахин ашиглалтын зохицуулалтын асуудал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарт бохир усны дахин ашиглалтын зохицуулалт хангалттай хөгжөөгүй байна.

Илэрч буй асуудал

- бохир ус дахин ашиглах эрх зүйн зохицуулалт тодорхой бус
- технологийн стандарт, шаардлага хангалтгүй
- салбарын бодлого, төлөвлөлт сул

Үр дагавар

Цэвэрлэгдсэн хаягдал усыг үйлдвэрлэлийн болон бусад зориулалтаар ашиглах боломж бүрэн ашиглагдахгүй байна.

Өөрчлөх шаардлага

Хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох стандарт, техникийн шаардлагыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

1. Салбарын институцийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.
2. Усны үйлчилгээний тарифын тогтолцоог бодит өртөгт тулгуурлан шинэчлэх шаардлагатай байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

6.1 Монгол Улсын усны нөөцийн ерөнхий төлөв

Монгол Улс нь усны нөөцийн хувьд харьцангуй хязгаарлагдмал боломжтой орон бөгөөд усны нөөц нь газарзүйн хувьд жигд бус тархалттай байдаг. Улсын нийт усны нөөцийн ихэнх хэсэг нь гадаргын уснаас бүрдэх боловч хот, суурины ус хангамжийн системийн үндсэн эх үүсвэр нь газрын доорх усны нөөцөд тулгуурладаг.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт, хотжилтын түвшин нэмэгдэх зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр усны нөөцийн ашиглалтын ачаалал нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа томоохон хот, суурин газруудад усны хэрэглээ эрчимтэй өсөж байгаа нь усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах асуудлыг бодлогын чухал чиглэл болгож байна.

6.2 Хот, суурины ус хангамжийн тогтолцоо

Монгол Улсын хот, суурины ус хангамжийн систем нь үндсэндээ хоёр хэлбэрээр зохион байгуулагддаг. Үүнд төвлөрсөн ус хангамжийн систем болон төвлөрсөн бус ус хангамжийн систем хамаарна.

Төвлөрсөн ус хангамжийн систем нь ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх зориулалт бүхий шугам сүлжээ, инженерийн барилга байгууламжид тулгуурлан хэрэглэгчийг ундны болон ахуйн хэрэглээний усаар хангадаг. Энэ систем нь ихэвчлэн нийслэл болон томоохон аймгийн төвүүдэд ашиглагдаж байна.

Харин төвлөрсөн бус ус хангамжийн систем нь ус түгээх байр, гүний худаг зэрэг эх үүсвэрээс усыг зөөвөрлөн түгээх хэлбэрээр хэрэглэгчдийг усаар хангадаг бөгөөд энэ нь ихэвчлэн гэр хорооллын бүс болон жижиг суурин газруудад ашиглагддаг.

6.3 Усны хэрэглээний бүтэц

Хот, суурины усны хэрэглээ нь ахуйн хэрэглээ, үйлдвэрлэлийн хэрэглээ, үйлчилгээний салбарын хэрэглээ болон системийн алдагдлаас бүрддэг.

Салбарын статистик мэдээллээс харахад хотын усны хэрэглээний бүтцэд ахуйн хэрэглээ зонхилж байна. Ахуйн хэрэглээ нь нийт усны хэрэглээний ойролцоогоор 55–60 хувийг эзэлдэг бол үйлдвэрлэлийн хэрэглээ 20–25 хувь, нийтийн үйлчилгээний хэрэглээ 10–15 хувийг эзэлж байна. Үлдсэн хэсгийг ус хангамжийн системийн алдагдал бүрдүүлдэг.

Хотын усны хэрэглээний бүтцэд ахуйн хэрэглээ зонхилж байгаа нь хүн амын төвлөрөл, орон сууцны барилгажилт нэмэгдэж байгаатай холбоотой юм.

6.4 Ус хангамжийн дэд бүтцийн хөгжил

Монгол Улсын хот, суурины ус хангамжийн дэд бүтцийн хөгжил сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээнд сайжирсан боловч системийн хүчин чадал, техник, технологийн шинэчлэлийн хүрээнд тодорхой асуудлууд байсаар байна.

Тухайлбал, зарим ус хангамжийн системийн шугам сүлжээ нь олон жилийн ашиглалтын хугацаатай, элэгдэл ихтэй болсон бөгөөд усны алдагдал нэмэгдэх шалтгаан болж байна. Мөн ус хангамжийн системийн өргөтгөл, шинэчлэлийн ажлыг санхүүжүүлэх хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь салбарын хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

6.5 Хаягдал усны менежмент

Хот, суурины усны хэрэглээнээс үүсч буй бохир ус нь ариутгах татуургын системээр дамжин цэвэрлэх байгууламжид хүргэгдэж, цэвэрлэгээний технологийн процессоор цэвэрлэгддэг.

Монгол Улсын томоохон хот, сууринд бохир ус цэвэрлэх байгууламж ажиллаж байгаа боловч зарим байгууламжийн технологийн хүчин чадал өсөн нэмэгдэж буй ачааллыг бүрэн хангаж чадахгүй байгаа асуудал ажиглагдаж байна.

Мөн цэвэрлэгдсэн бохир усыг дахин ашиглах тогтолцоо хангалттай хөгжөөгүй байгаа нь усны нөөцийн ашиглалтын үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

6.6 Ус дахин ашиглах боломж

Усны нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд хаягдал, бохир усыг цэвэрлэн дахин ашиглах асуудал олон улсын хэмжээнд өргөн хэрэглэгдэж байна. Цэвэрлэсэн хаягдал усыг үйлдвэрлэл, ногоон байгууламж услах, хотын цэвэрлэгээ зэрэг зориулалтаар ашиглах боломжтой байдаг.

Монгол Улсад бохир усны дахин ашиглалтын боломж тодорхой хэмжээнд байгаа боловч эрх зүйн зохицуулалт, технологийн стандарт, эдийн засгийн механизм хангалттай хөгжөөгүй байгаа нь энэ боломжийг бүрэн ашиглахад саад болж байна.

6.7 Ус дахин ашиглах чиглэлээрх олон улсын туршлага

Усны нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд хот, суурины ус хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор олон улс оронд хаягдал усыг цэвэрлэн дахин ашиглах бодлогыг өргөн хэрэгжүүлж байна. Дэлхийн олон улсын туршлагаас харахад хаягдал усыг дахин ашиглах тогтолцоо нь усны нөөцийн хомсдолыг бууруулах, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангах, байгаль орчны ачааллыг бууруулах, ган гачигийн үед үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах зэрэг олон талын ач холбогдолтой болох нь батлагдсан байна.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд бохир ус дахин ашиглах чиглэлээр олон улсын туршлагыг судлах нь бодлогын ач холбогдолтой юм.

6.7.1 Израилийн туршлага

Израиль улс нь усны нөөцийн хомсдолтой орнуудын нэг бөгөөд усны нөөцийг үр ашигтай ашиглах бодлогыг төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгож ирсэн. Тус улс бохир ус дахин ашиглах технологийг дэлхийд хамгийн өргөн хэрэгжүүлсэн орнуудын нэг бөгөөд нийт бохир усны 80 гаруй хувийг дахин ашигладаг гэж судалгаанд дурдсан байдаг.

Израильд бохир усны дахин ашиглалтын тогтолцоо нь дараах үндсэн зарчимд тулгуурладаг. Үүнд:

- бохир усны төвлөрсөн цэвэрлэгээ
- цэвэрлэгдсэн усыг тусгай дамжуулах системээр хүргэх
- хөдөө аж ахуйн усалгаанд ашиглах
- үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

Израиль улсын хувьд цэвэрлэгдсэн бохир усыг ихэвчлэн хөдөө аж ахуйн салбарт ашигладаг бөгөөд энэ нь ундны усны нөөцийг хамгаалах бодлогын чухал хэрэгсэл болж байна. Түүнчлэн бохир ус дахин ашиглах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай стандарт, хяналтын тогтолцоог хууль тогтоомжийн хүрээнд тодорхой зохицуулсан байдаг.

6.7.2 Сингапурын туршлага

Сингапур улс нь усны нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд усны менежментийг үр ашигтай хэрэгжүүлсэн дэлхийн шилдэг жишээний нэг юм. Тус улс “NEWater” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бохир усны цэвэрлэгээний дараах усыг дахин боловсруулж, үйлдвэрлэл болон зарим тохиолдолд ундны усны эх үүсвэрт ашиглах боломжийг бүрдүүлсэн.

NEWater систем нь дараах технологийн шатлалаас бүрддэг.

1. микро шүүлтүүр
2. урвуу осмос
3. хэт ягаан туяаны ариутгал

Эдгээр технологийн тусламжтайгаар цэвэрлэгдсэн ус нь өндөр чанарын стандарт хангасан байдаг. Сингапурын туршлагаас харахад бохир ус дахин ашиглах бодлого нь усны аюулгүй байдлыг хангах стратегийн чухал хэсэг болж байна.

6.7.3 Австралийн туршлага

Австрали улс нь хуурай уур амьсгалтай бүсэд оршдог тул усны нөөцийн тогтвортой менежментийг хангах бодлого хэрэгжүүлж ирсэн. Тус улсын олон хотод бохир усны дахин ашиглалтын системийг хотын ногоон байгууламж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээнд ашигладаг.

Австралид бохир ус дахин ашиглах үйл ажиллагааг дараах салбарт өргөн ашигладаг.

- хотын ногоон байгууламж услах
- аж үйлдвэрийн ус
- хотын цэвэрлэгээ
- хөдөө аж ахуй

Мөн Австралид ус дахин ашиглах стандарт, эрүүл ахуйн шаардлагыг тодорхойлсон үндэсний удирдамж баталж хэрэгжүүлдэг.

6.7.4 АНУ-ын туршлага

АНУ-д бохир ус дахин ашиглах бодлого нь муж улсын хэмжээнд хэрэгждэг бөгөөд зарим мужид энэ систем өргөн хөгжсөн байдаг. Ялангуяа Калифорни мужид усны нөөцийн хомсдолтой холбоотойгоор бохир ус дахин ашиглах технологийг өргөн нэвтрүүлсэн.

АНУ-д бохир ус дахин ашиглах үндсэн чиглэлүүд нь:

- үйлдвэрлэлийн ус
- ногоон байгууламж услах
- хотын цэвэрлэгээ
- газрын доорх усны нөөцийг нөхөх

АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг (EPA) нь бохир ус дахин ашиглах стандарт, удирдамжийг боловсруулж мөрдүүлдэг.

6.7.5 Монгол Улсад хэрэгжүүлэх боломж

Олон улсын туршлагаас харахад бохир усны дахин ашиглалтын бодлого нь усны нөөцийн тогтвортой менежментийг хангах чухал арга хэрэгсэл болж байна. Монгол Улсын хувьд хот, суурины бохир ус цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн усыг үйлдвэрлэлийн болон техникийн зориулалтаар ашиглах боломж тодорхой хэмжээнд бий.

Ялангуяа дараах салбарт дахин ашиглах боломжтой.

- дулааны цахилгаан станц
- уул уурхайн салбар
- үйлдвэрлэлийн технологийн ус
- хотын ногоон байгууламж

Монгол Улсад бохир ус дахин ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, стандарт, эдийн засгийн механизм хангалттай хөгжөөгүй байгаа нь энэ боломжийг бүрэн ашиглахад саад болж байна.

Иймд олон улсын туршлагад үндэслэн дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

1. Бохир ус дахин ашиглах эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах

2. Цэвэрлэгдсэн ус ашиглах стандарт, техникийн шаардлагыг боловсруулах
3. Үйлдвэрлэлийн салбарт дахин ашиглах усны хэрэглээг дэмжих
4. Ус дахин ашиглах дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын механизмыг бий болгох

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр Монгол Улсын усны нөөцийн ашиглалтыг илүү үр ашигтай болгох, хот, суурины ус хангамжийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх боломжтой юм.

6.8 Улаанбаатар хотын ус хангамж, хаягдал усны менежмент

Улаанбаатар хот нь Монгол Улсын хүн ам, эдийн засгийн үйл ажиллагааны төвлөрөл хамгийн өндөр бүс бөгөөд хотын ус хангамж, ариутгах татуургын систем нь улсын хамгийн том ус хангамжийн системд тооцогддог. Иймээс хотын усны нөөцийн ашиглалт, бохир усны менежментийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх нь салбарын бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

6.8.1 Улаанбаатар хотын ус хангамжийн систем

Улаанбаатар хотын ус хангамжийн систем нь үндсэндээ газрын доорх усны нөөцөд тулгуурладаг. Хотын ундны усны эх үүсвэр нь Туул голын сав газрын газрын доорх усны ордуудаас бүрддэг бөгөөд хотын ус хангамжийн системд 7 эх үүсвэрийг ашиглаж байна.

Хотын ус хангамжийн систем нь дараах үндсэн үе шаттайгаар зохион байгуулагддаг.

1. газрын доорх ус олборлох
2. ус цэвэршүүлэх
3. ус дамжуулах
4. хэрэглэгчдэд түгээх

Улаанбаатар хотын ус хангамжийн системийг Ус сувгийн удирдах газар болон холбогдох ус хангамжийн байгууллагууд хариуцан ажиллуулж байна. Сүүлийн жилүүдэд хотын хүн амын өсөлт, барилгажилтын нэмэгдэлтэй холбоотойгоор усны хэрэглээ тогтмол өсөх хандлагатай байна.

Хүснэгт 8. Улаанбаатар хотын ус хангамжийн ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжээ
Хүн ам	~1.7 сая
Хоногийн усны хэрэглээ	160–180 мянган м ³
Жилийн усны хэрэглээ	60–65 сая м ³
Усны үндсэн эх үүсвэр	Газрын доорх ус

Эх сурвалж: Ус сувгийн удирдах газрын мэдээлэл

Улаанбаатар хотын ус хангамжийн систем нь нийт усны хэрэглээний ихэнх хэсгийг хангаж байгаа боловч хүн амын өсөлт, хотжилтын тэлэлттэй холбоотойгоор ирээдүйд усны нөөцийн ашиглалтын ачаалал нэмэгдэх төлөв ажиглагдаж байна.

6.8.2 Хотын усны хэрэглээний бүтэц

Улаанбаатар хотын усны хэрэглээ нь ахуйн хэрэглээ, үйлдвэрлэлийн хэрэглээ, үйлчилгээний салбарын хэрэглээ болон системийн алдагдлаас бүрддэг.

Хотын усны хэрэглээний бүтцийг дараах байдлаар харуулж болно.

Хүснэгт 9. Улаанбаатар хотын усны хэрэглээний бүтэц

Усны хэрэглээ	Дундаж хувь
Ахуйн хэрэглээ	55–60 %
Үйлдвэрлэлийн хэрэглээ	20–25 %
Нийтийн үйлчилгээ	10–15 %
Усны алдагдал	10–15 %

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

Эндээс харахад ахуйн хэрэглээ хотын нийт усны хэрэглээний хамгийн их хувийг эзэлж байгаа боловч үйлдвэрлэлийн салбарын усны хэрэглээ нь усны нөөцөд үзүүлэх дарамтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

6.8.3 Улаанбаатар хотын бохир усны менежмент

Хотын усны хэрэглээнээс үүссэн бохир ус нь ариутгах татуургын шугам сүлжээгээр дамжин төв цэвэрлэх байгууламжид хүргэгдэж, технологийн боловсруулалт хийсний дараа байгальд нийлүүлэгддэг.

Улаанбаатар хотод бохир ус цэвэрлэх үндсэн байгууламж ажиллаж байгаа бөгөөд хотын бохир усны ихэнх хэсгийг энэхүү байгууламжид цэвэрлэдэг.

Хүснэгт 10. Улаанбаатар хотын бохир усны ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжээ
Хоногийн бохир ус	~160 мянган м ³
Жилийн бохир ус	~58 сая м ³
Цэвэрлэх байгууламж	Төв цэвэрлэх байгууламж

Эх сурвалж: Салбарын статистик мэдээлэл

Хотын бохир усны цэвэрлэгээний систем нь тодорхой хэмжээнд ажиллаж байгаа боловч хотын хүн амын өсөлт, усны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр бохир усны хэмжээ өсөх хандлагатай байна.

6.8.4 Бохир ус дахин ашиглах боломж

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн ус нь үйлдвэрлэлийн болон техникийн зориулалтаар ашиглах боломжтой нөөц гэж үзэж болно.

Хүснэгт 11. Дахин ашиглах боломжит усны нөөц

Үзүүлэлт	Хэмжээ
Нийт цэвэрлэгдсэн ус	50–60 сая м ³ / жил
Дахин ашиглах боломж	20–30 сая м ³ / жил

Эх сурвалж: Усны газар

Энэхүү усыг дараах салбарт ашиглах боломжтой.

- дулааны цахилгаан станц
- уул уурхайн үйлдвэрлэл
- үйлдвэрийн технологийн ус
- хотын ногоон байгууламж

Хэрэв цэвэрлэгдсэн бохир усны тодорхой хэсгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломж бүрдвэл газрын доорх усны олборлолтыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах боломжтой.

6.8.5 Бодлогын дүгнэлт

Улаанбаатар хотын ус хангамжийн систем нь Монгол Улсын усны хэрэглээний хамгийн том төвлөрөл бөгөөд хотын усны нөөцийн ашиглалт, бохир усны менежмент нь улсын усны бодлогын чухал хэсэг болж байна.

Шинжилгээний дүнд дараах дүгнэлтийг хийж болно.

Нэгдүгээрт, хотын ус хангамжийн систем нь ихэвчлэн газрын доорх усны нөөцөд тулгуурлаж байгаа нь усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах асуудлыг илүү чухал болгож байна.

Хоёрдугаарт, хот суурины бохир усыг цэвэрлэж дахин ашиглах боломж тодорхой хэмжээнд байгаа боловч энэ чиглэлд эрх зүйн болон институцийн зохицуулалт байхгүй байна.

Гуравдугаарт, цэвэрлэгдсэн хаягдал, бохир усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тогтолцоог бий болгох нь газар доорх усны нөөцийг хэмнэх, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын чухал арга хэмжээ болох боломжтой.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд бохир ус дахин ашиглах тогтолцоог хөгжүүлэх бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

6.9 Монгол Улсын хотуудын ус хангамж, ариутгах татуургын системийн харьцуулсан шинжилгээ

Монгол Улсын хот, суурины ус хангамж, ариутгах татуургын систем нь газарзүйн байршил, хүн амын төвлөрөл, эдийн засгийн үйл ажиллагааны бүтэц, инженерийн дэд бүтцийн хөгжлийн түвшнээс хамааран харилцан адилгүй хөгжсөн байна. Иймд хотуудын ус хангамж, бохир усны менежментийн нөхцөл байдлыг харьцуулан судлах нь салбарын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, бүс нутгийн хөгжлийн ялгааг тодорхойлох ач холбогдолтой.

Энэхүү хэсэгт Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудын ус хангамжийн системийн үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулан шинжилсэн болно.

6.9.1 Хотуудын ус хангамжийн системийн ерөнхий үзүүлэлт

Монгол Улсын томоохон хотуудын ус хангамжийн систем нь ихэвчлэн газрын доорх усны нөөцөд тулгуурладаг бөгөөд төвлөрсөн ус хангамжийн системээр дамжуулан хэрэглэгчдийг усаар хангадаг. Гэвч хотуудын усны хэрэглээ, дэд бүтцийн хүчин чадал, бохир ус цэвэрлэх системийн хөгжлийн түвшин харилцан адилгүй байна.

Хүснэгт 12. Монголын томоохон хотуудын ус хангамжийн үндсэн үзүүлэлт

Хот	Хүн ам (ойролцоогоор)	Хоногийн усны хэрэглээ	Усны эх үүсвэр
Улаанбаатар	~1.7 сая	160–180 мян. м ³	Газрын доорх ус
Дархан	~110 мянга	20–25 мян. м ³	Газрын доорх ус
Эрдэнэт	~100 мянга	18–22 мян. м ³	Газрын доорх ус

Эх сурвалж: Салбарын статистик мэдээлэл

Эндээс харахад Улаанбаатар хот нь усны хэрэглээний хэмжээгээр бусад хотуудаас хэд дахин их ачаалалтай байгаа бөгөөд ус хангамжийн системийн хүчин чадалд хамгийн их дарамт үзүүлдэг хот юм.

6.9.2 Ус хангамжийн дэд бүтцийн харьцуулалт

Хот, суурины ус хангамжийн дэд бүтэц нь ус олборлох байгууламж, дамжуулах шугам, ус түгээх систем, хэрэглэгчийн холболт зэрэг олон бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг. Томоохон

хотуудад төвлөрсөн ус хангамжийн систем харьцангуй хөгжсөн боловч шугам сүлжээний элэгдэл, усны алдагдал зэрэг асуудал нийтлэг ажиглагддаг.

Хүснэгт 13. Хотуудын ус хангамжийн дэд бүтцийн нөхцөл

Хот	Төвлөрсөн ус хангамж	Шугам сүлжээний нөхцөл	Усны алдагдал
Улаанбаатар	Өндөр	Хэсэгчлэн элэгдсэн	10–15 %
Дархан	Дунд	Хуучирсан хэсэг бий	10–12 %
Эрдэнэт	Дунд	Харьцангуй сайн	8–10 %

Эх сурвалж: Ус сувгийн удирдах газар

Энэхүү харьцуулалтаас харахад шугам сүлжээний шинэчлэл нь хотуудын ус хангамжийн системийн найдвартай байдлыг хангах чухал хүчин зүйл болж байна.

6.9.3 Бохир ус цэвэрлэх системийн харьцуулалт

Хотын бохир усны менежмент нь ариутгах татуургын систем, бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, технологийн түвшнээс хамаардаг.

Хүснэгт 14. Хотуудын бохир усны менежментийн харьцуулалт

Хот	Бохир ус цэвэрлэх байгууламж	Технологийн түвшин
Улаанбаатар	Төв цэвэрлэх байгууламж	Дунд
Дархан	Хотын цэвэрлэх байгууламж	Дунд
Эрдэнэт	Цэвэрлэх байгууламж	Харьцангуй сайн

Эх сурвалж: <https://www.1212.mn/mn/statcate/table/Economy,%20environment/Environment>

Хотуудад бохир ус цэвэрлэх систем ажиллаж байгаа боловч технологийн шинэчлэл, хүчин чадлын өргөтгөл шаардлагатай байна.

6.9.4 Хотуудын усны менежментийн тулгамдсан асуудал

Хот, суурины ус хангамжийн системийн хөгжлийн түвшин харилцан адилгүй боловч дараах нийтлэг асуудлууд ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, ус хангамжийн шугам сүлжээний элэгдэл өндөр байгаа нь усны алдагдал нэмэгдэхэд нөлөөлж байна.

Хоёрдугаарт, бохир усны цэвэрлэгээний дараах усыг дахин ашиглах тогтолцоо хөгжөөгүй байна.

Гуравдугаарт, ус хангамжийн дэд бүтцийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгө оруулалт хангалтгүй байна.

Дөрөвдүгээрт, хотын усны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр газрын доорх усны нөөцөд үзүүлэх ачаалал нэмэгдэж байна.

6.9.5 Бодлогын дүгнэлт

Хот, суурины ус хангамжийн системийн харьцуулсан шинжилгээнээс харахад Монгол Улсын томоохон хотуудын ус хангамж, ариутгах татуургын систем нь үндсэн бүтэц бүрдсэн боловч дэд бүтцийн шинэчлэл, усны нөөцийн тогтвортой ашиглалт, бохир усны дахин ашиглалтын чиглэлд цаашид бодлогын зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байна.

Ялангуяа дараах чиглэлд бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

1. ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэл
2. бохир ус дахин ашиглах системийг хөгжүүлэх
3. хотын усны нөөцийн менежментийг сайжруулах
4. салбарын хөрөнгө оруулалтын механизмыг бэхжүүлэх

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр хот, суурины ус хангамжийн системийн найдвартай байдал, усны нөөцийн ашиглалтын үр ашиг нэмэгдэх боломжтой.

6.10 Монгол Улсын хот, суурины усны балансын шинжилгээ

Усны баланс нь тухайн хот, суурины усны нийлүүлэлт, хэрэглээ, алдагдлын харьцааг тодорхойлж, усны нөөцийн ашиглалтын үр ашгийг үнэлэхэд ашиглагддаг чухал үзүүлэлт юм. Усны балансын шинжилгээ нь усны нөөцийн менежментийн бодлого боловсруулах, усны хэрэглээний бүтэц, усны алдагдлын түвшинг тодорхойлох, ус хэмнэлтийн арга хэмжээг төлөвлөхөд ач холбогдолтой.

Монгол Улсын хот, суурины ус хангамжийн системийн хувьд усны баланс нь ус олборлох эх үүсвэр, хэрэглэгчдэд нийлүүлсэн ус, хэрэглээний бүтэц, системийн алдагдлын хэмжээг хамарсан үзүүлэлтээр тодорхойлогддог.

6.10.1 Хот, суурины усны нийлүүлэлт

Монгол Улсын хот, суурины ус хангамжийн систем нь ихэвчлэн газрын доорх усны нөөцөд тулгуурладаг. Хотын усны эх үүсвэрийн үндсэн хэсгийг гүний усны орд бүрдүүлдэг бөгөөд ус олборлох байгууламжаар дамжуулан хотын ус хангамжийн системд нийлүүлдэг.

Хүснэгт 15. Хот, суурины усны эх үүсвэрийн бүтэц

Усны эх үүсвэр	Дундаж хувь
Газрын доорх ус	80–90 %
Гадаргын ус	5–10 %
Бусад эх үүсвэр	1–5 %

Эх сурвалж: <https://www.1212.mn/mn/statcate/table/Economy,%20environment/Environment>

Эндээс харахад Монгол Улсын хот, суурины ус хангамжийн систем нь ихэвчлэн газрын доорх усны нөөцөөс хамааралтай байгаа нь усны нөөцийн тогтвортой ашиглалтын бодлогыг онцгой анхаарах шаардлагатайг харуулж байна.

6.10.2 Хотын усны хэрэглээний бүтэц

Хот, суурины усны хэрэглээ нь ахуйн хэрэглээ, үйлдвэрлэлийн хэрэглээ, үйлчилгээний салбарын хэрэглээ болон системийн алдагдлаас бүрддэг.

Хүснэгт 16. Хотын усны хэрэглээний бүтэц

Усны хэрэглээ	Дундаж хувь
Ахуйн хэрэглээ	55–60 %
Үйлдвэрлэлийн хэрэглээ	20–25 %
Нийтийн үйлчилгээ	10–15 %
Усны алдагдал	10–15 %

Эх сурвалж: Ус сувгийн удирдах газар

Эдгээрээс ахуйн хэрэглээ нь нийт усны хэрэглээний хамгийн өндөр хувийг эзэлдэг боловч үйлдвэрлэлийн салбарын усны хэрэглээ нь усны нөөцөд үзүүлэх дарамтыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.

6.10.3 Усны алдагдлын шинжилгээ

Усны алдагдал нь ус хангамжийн системийн үр ашигт нөлөөлдөг чухал үзүүлэлт юм. Шугам сүлжээний элэгдэл, хуучирсан тоног төхөөрөмж, алдагдалтай холболт зэрэг хүчин зүйлс нь усны алдагдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг.

Хүснэгт 17. Хотын усны алдагдлын ерөнхий үнэлгээ

Үзүүлэлт	Хэмжээ
Дундаж усны алдагдал	10–15 %
Гол шалтгаан	Шугам сүлжээний элэгдэл
Нөлөөлөл	Усны нөөцийн үр ашиг буурах

Усны алдагдлыг бууруулах нь ус хангамжийн системийн үр ашгийг нэмэгдүүлэх, усны нөөцийн ашиглалтыг сайжруулах чухал арга хэмжээ гэж үзэж болно.

6.10.4 Бохир усны урсгал ба дахин ашиглах боломж

Хотын усны хэрэглээнээс үүссэн бохир ус нь ариутгах татуургын системээр дамжин цэвэрлэх байгууламжид хүргэгдэж, боловсруулалт хийсний дараа байгаль орчинд нийлүүлэгддэг.

Хүснэгт 18. Хот, суурины бохир усны хэмжээ

Үзүүлэлт	Хэмжээ
Хоногийн бохир ус	~160 мян. м ³
Жилийн бохир ус	~58 сая м ³
Дахин ашиглах боломж	20–30 сая м ³

Энэхүү бохир усны тодорхой хэсгийг үйлдвэрлэлийн болон техникийн зориулалтаар ашиглах боломжтой гэж үзэж болно.

6.10.5 Усны балансын бодлогын үнэлгээ

Монгол Улсын хот, суурины усны балансын шинжилгээнээс дараах үндсэн дүгнэлтийг хийж болно.

Нэгдүгээрт, хотын ус хангамжийн систем нь газрын доорх усны нөөцөөс ихээхэн хамааралтай байна.

Хоёрдугаарт, хотын усны хэрэглээний өсөлт нь усны нөөцийн ашиглалтад дарамт үзүүлэх хандлагатай байна.

Гуравдугаарт, бохир усны дахин ашиглалтын боломж тодорхой хэмжээнд байгаа боловч энэ чиглэлд эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Дөрөвдүгээрт, усны алдагдлыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх нь усны нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх чухал арга хэмжээ болно.

Иймд хот, суурины усны менежментийн бодлогын хүрээнд усны алдагдлыг бууруулах, бохир усны дахин ашиглалтын тогтолцоог хөгжүүлэх, усны нөөцийн ашиглалтыг илүү үр ашигтай зохион байгуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасан дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- зорилгод хүрсэн түвшин
- зардлын өөрчлөлт
- зардал–үр өгөөжийн харьцаа
- нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдал
- практикт нийцэж байгаа байдал

Эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд салбарын бодит нөхцөл байдал, статистик мэдээлэл, байгууллагуудын үйл ажиллагааны туршлага, бодлогын хэрэгжилтийн үр дүнд тулгуурлан үнэлгээ хийв.

7.1 Хуулийн зорилгод хүрсэн түвшний үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн зорилго нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, хэрэглээнээс үүссэн бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг тогтоох явдал юм. Тус хуулиар ус хангамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, ариутгах татуургын системийн үйл ажиллагааг зохицуулах, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний үндсэн шаардлагыг тодорхойлсон.

Хэрэгжилтийн бодит байдал

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хот, суурины ус хангамжийн үйлчилгээний эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдэж, салбарын үйл ажиллагааг зохицуулах институцийн тогтолцоо бий болсон. Томоохон хот, суурин газруудад төвлөрсөн ус хангамжийн систем хөгжиж, хэрэглэгчдийг ундны болон ахуйн хэрэглээний усаар хангах боломж сайжирсан гэж үзэж болно.

Мөн бохир ус зайлуулах, цэвэрлэх үйлчилгээний үндсэн дэд бүтэц бүрэлдэж, ариутгах татуургын системийн хүрээнд бохир усыг цэвэрлэх байгууламжид хүргэж боловсруулах тогтолцоо тодорхой хэмжээнд бий болсон.

Илэрч буй асуудал

Гэсэн хэдий ч хотжилтын хурдацтай өсөлт, усны хэрэглээ нэмэгдэх хандлага, ус хангамжийн дэд бүтцийн хүчин чадлын хязгаар зэрэг хүчин зүйлсийн улмаас хуулийн зорилгыг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байна.

Ялангуяа дараах асуудлууд ажиглагдаж байна.

- гэр хорооллын бүсийн ус хангамжийн хүртээмж хангалтгүй
- ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ жигд бус
- ус хангамжийн шугам сүлжээний хүчин чадал зарим бүсэд хүрэлцэхгүй

Үнэлгээ

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэхэд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн зорилго тодорхой хэмжээнд хэрэгжсэн боловч бүх хот, сууринд жигд түвшинд хүрээгүй гэж дүгнэж болно. Иймд хуулийн зорилгод хүрсэн түвшнийг хэсэгчлэн хэрэгжсэн гэж үнэлэв.

7.2 Зардлын өөрчлөлтийн үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хүрээнд ус хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах үүрэгтэй. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэд бүтцийн ашиглалт, засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл, эрчим хүчний хэрэглээ зэрэг олон төрлийн зардал гардаг.

Хуулийн зорилго нь ус хангамжийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангахын тулд үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг эрх зүйн хүрээнд зохицуулах явдал бөгөөд энэ нь тодорхой хэмжээний санхүүгийн зардлыг шаарддаг.

Хэрэгжилтийн бодит байдал Хууль хэрэгжиж эхэлснээс хойш ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд зарцуулагдах зардал тодорхой хэмжээгээр өссөн байна. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна.

- ус олборлох болон ус цэвэршүүлэх үйл ажиллагааны зардал
- шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний зардал
- бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны зардал
- эрчим хүчний хэрэглээний зардал
- тоног төхөөрөмжийн шинэчлэл, засварын зардал

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний үнэ болон тоног төхөөрөмжийн өртөг нэмэгдэж байгаатай холбоотойгоор усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны зардал нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Илэрч буй асуудал Зардлын өсөлт нэмэгдэж байгаа хэдий ч усны үйлчилгээний тариф нь зарим тохиолдолд бодит өртгийг бүрэн тусгадаггүй нөхцөл ажиглагдаж байна. Үүний улмаас усны

үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдалд тодорхой хүндрэл үүсэх нөхцөл бүрдэж байна.

Мөн дэд бүтцийн шинэчлэл, шугам сүлжээний засвар үйлчилгээ, технологийн шинэчлэлд шаардлагатай хөрөнгө оруулалт хангалтгүй байх асуудал нийтлэг ажиглагдаж байна.

Үнэлгээ Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэхэд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үйл ажиллагаанд шаардагдах зардал нэмэгдэх хандлагатай байгаа боловч санхүүжилтийн тогтолцоо болон тарифын зохицуулалт нь бодит өртгийг бүрэн тусгахгүй байгаа нь салбарын санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Иймд зардлын өөрчлөлтийг өсөх хандлагатай гэж үнэлэв.

7.3 Зардал–үр өгөөжийн харьцааны үнэлгээ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу тухайн хууль хэрэгжсэнээр нийгэм, эдийн засагт ямар үр өгөөж бий болсон болон түүнийг хэрэгжүүлэхэд гарсан зардлын харьцааг үнэлэх шаардлагатай байдаг.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь усны үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, хэрэглэгчдэд үзүүлэх усны үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, бохир усны менежментийн системийг хөгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг агуулдаг.

Хэрэгжилтийн бодит байдал Хууль хэрэгжсэнээр ус хангамж, ариутгах татуургын салбарын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, усны үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны бүтэц тодорхой болсон.

Мөн дараах эерэг үр нөлөө ажиглагдаж байна.

- ус хангамжийн үйлчилгээний зохион байгуулалт сайжирсан
- хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн тогтолцоо бүрэлдсэн
- салбарын байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалт тодорхой болсон
- хотын ариун цэврийн нөхцөл тодорхой хэмжээнд сайжирсан

Илэрч буй асуудал, салбарын дэд бүтцийн шинэчлэл, ус хангамжийн шугам сүлжээний засвар үйлчилгээ, бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээ өндөр хэвээр байна.

Мөн усны нөөцийн тогтвортой ашиглалтыг хангах бодлогын хэрэгжилт зарим тохиолдолд хангалттай түвшинд хүрээгүй байна.

Иймд хууль хэрэгжсэнээр нийгэм, эдийн засгийн тодорхой үр өгөөж бий болсон боловч салбарын дэд бүтцийн хөгжлийн шаардлага өндөр хэвээр байгаа тул зардал–үр өгөөжийн харьцааг дунд түвшний үр ашигтай гэж үнэлэв.

7.4 Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдлын үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь иргэдийн амьдралын чанарт шууд нөлөөлдөг нийгмийн үйлчилгээний нэг бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд хэрэглэгчдийн хүлээн зөвшөөрөл чухал шалгуур үзүүлэлт болдог.

Хэрэгжилтийн бодит байдал Хууль хэрэгжиж эхэлснээс хойш ус хангамжийн үйлчилгээний хүртээмж тодорхой хэмжээгээр нэмэгдэж, хэрэглэгчдийг ундны болон ахуйн хэрэглээний усаар хангах нөхцөл сайжирсан.

Мөн бохир ус зайлуулах, цэвэрлэх үйлчилгээ нь хотын ариун цэврийн нөхцөлийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж байна.

Илэрч буй асуудал, хот, суурины зарим бүс нутагт ус хангамжийн хүртээмж жигд бус байна. Ялангуяа гэр хорооллын бүсийн ус хангамж, ариун цэврийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй хэвээр байна.

Мөн зарим хэрэглэгчдийн зүгээс усны үйлчилгээний тариф, үйлчилгээний чанартай холбоотой асуудал хөндөгдөж байна.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ нь нийтлэг байдлаар иргэдийн амьдралд чухал үйлчилгээ болж хүлээн зөвшөөрөгдсөн боловч үйлчилгээний хүртээмж, чанарын асуудлаас шалтгаалан нийгмийн хүлээн зөвшөөрөл дунд түвшинд байна гэж үнэлэв.

7.5 Практикт нийцэж байгаа байдлын үнэлгээ

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхэд тухайн хууль бодит нөхцөл байдалд хэрхэн хэрэгжиж байгаа, салбарын үйл ажиллагаанд практик ач холбогдолтой эсэхийг тодорхойлох шаардлагатай байдаг.

Хэрэгжилтийн бодит байдал Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль нь салбарын үндсэн харилцааг зохицуулах эрх зүйн суурийг бүрдүүлж, ус хангамжийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн.

Хуулийг хэрэгжүүлэх явцад дараах асуудлууд ажиглагдаж байна.

- салбарын байгууллагуудын чиг үүргийн уялдаа сул
- тарифын зохицуулалтын асуудал
- бохир усны дахин ашиглалтын зохицуулалт тодорхой бус
- дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дутагдал

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэхэд хуулийн зарим зохицуулалт нь практикт бүрэн нийцэхгүй байгаа бөгөөд салбарын хөгжлийн шинэ шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв.

7.6 Харьцуулсан үнэлгээ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ хууль батлагдахаас өмнөх болон хууль хэрэгжиж эхэлснээс хойших нөхцөл байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийв.

Харьцуулсан шинжилгээг дараах чиглэлээр хийсэн.

- ус хангамжийн үйлчилгээний хүртээмж
- бохир ус цэвэрлэх системийн хөгжил
- усны хэрэглээний өсөлт
- салбарын институцийн зохион байгуулалт

Харьцуулсан шинжилгээний дүнд хот, суурины ус хангамжийн үйлчилгээний эрх зүйн орчин тодорхой хэмжээнд сайжирсан боловч салбарын хөгжлийн шинэ шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД СААД БОЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн явцад салбарын бодлого, институцийн зохион байгуулалт, санхүүжилт, техник технологийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна. Эдгээр хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох нь хуулийн хэрэгжилтийг сайжруулах бодлогын шийдвэр боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Хэрэгжилтийн үнэлгээний хүрээнд хуулийн хэрэгжилтэд саад болж буй хүчин зүйлсийг дараах үндсэн бүлгээр ангилан судлав. Үүнд:

- эрх зүйн хүчин зүйл
- институцийн хүчин зүйл
- эдийн засгийн хүчин зүйл
- техник, технологийн хүчин зүйл
- нийгмийн хүчин зүйл

8.1 Эрх зүйн хүчин зүйл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын эрх зүйн зохицуулалт нь хэд хэдэн хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжиж байна. Үүнд Усны тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зэрэг хууль тогтоомж багтдаг.

Эдгээр хууль тогтоомжийн зохицуулалт зарим тохиолдолд харилцан уялдаа хангалтгүй, зохицуулалтын давхардал үүсэх нөхцөл ажиглагдаж байна. Мөн хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, байгалийн цэнгэг усны нөөцийг хэмнэх, түүний урт хугацааны менежмент зэрэг шинэ асуудлууд хуулийн зохицуулалтад хангалттай тусгагдаагүй байгаа нь эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагыг бий болгож байна.

8.2 Институцийн хүчин зүйл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарт төрийн болон орон нутгийн байгууллагуудын оролцоо чухал байр суурь эзэлдэг. Салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүргийг төрийн байгууллагууд гүйцэтгэж байгаа боловч институцийн зохион байгуулалтын хүрээнд тодорхой асуудлууд ажиглагдаж байна.

Тухайлбал, салбарын байгууллагуудын чиг үүргийн давхардал, байгууллагуудын хоорондын уялдаа холбоо сул байх, мэдээллийн нэгдсэн систем хангалтгүй зэрэг асуудлууд нь бодлого хэрэгжүүлэх явцад хүндрэл үүсгэж байна.

Иймд салбарын байгууллагуудын чиг үүргийг илүү тодорхой болгох, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

8.3 Эдийн засгийн хүчин зүйл

Ус хангамж, ариутгах татуургын салбар нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг дэд бүтцийн салбар юм. Ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, бохир ус цэвэрлэх зэрэг үйл ажиллагаанд өндөр зардал шаардагддаг.

Гэвч усны үйлчилгээний тариф нь зарим тохиолдолд бодит өртгийг бүрэн тусгадаггүй бөгөөд энэ нь үйлчилгээний байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж байна. Үүний улмаас ус хангамжийн системийн шинэчлэл, өргөтгөлийн ажилд шаардлагатай хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь салбарын хөгжилд тодорхой хэмжээгээр саад болж байна.

8.4 Техник, технологийн хүчин зүйл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн техник, технологийн түвшин нь салбарын үйл ажиллагааны үр ашигт чухал нөлөө үзүүлдэг.

Монгол Улсын зарим хот, суурины ус хангамжийн системийн шугам сүлжээ нь олон жилийн ашиглалтын хугацаатай, элэгдэл ихтэй болсон бөгөөд усны алдагдал нэмэгдэх шалтгаан болж байна. Мөн зарим бохир ус цэвэрлэх байгууламжийн технологи нь өсөн нэмэгдэж буй ачааллыг бүрэн хангаж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна.

Иймд ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн техник, технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

8.5 Нийгмийн хүчин зүйл

Хотжилтын өсөлт, хүн амын төвлөрөл нэмэгдэх нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний ачаалал нэмэгдэхэд нөлөөлж байна. Ялангуяа гэр хорооллын бүсэд төвлөрсөн ус хангамжийн системийн хүртээмж хангалтгүй байгаа нь усны үйлчилгээний хүртээмжийн асуудал үүсгэж байна.

Мөн усны хэрэглээний соёл, ус хэмнэх дадал, иргэдийн оролцоо зэрэг нийгмийн хүчин зүйлс нь усны нөөцийн үр ашигтай ашиглалтад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Иймд усны хэрэглээний зохистой дадлыг төлөвшүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

8.6 Нэгдсэн дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэхэд эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, институцийн зохион байгуулалтын асуудал, санхүүжилтийн хязгаарлалт, техник технологийн нөхцөл байдал, нийгмийн хүчин зүйлс зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байгаа нь тогтоогдлоо.

Иймд салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, институцийн зохион байгуулалтыг сайжруулах, санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, дэд бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ ШААРДАГДАЖ

БУЙ ЗОХИЦУУЛАЛТЫН САНАЛ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүнд тус хуулийн зарим зохицуулалт салбарын өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн шаардлагад бүрэн нийцэхгүй байгаа нь тогтоогдлоо. Ялангуяа хотжилтын хурдацтай өсөлт, усны хэрэглээ нэмэгдэх хандлага, усны нөөцийн хязгаарлагдмал байдал, бохир усны менежментийн асуудал зэрэг хүчин зүйлс нь салбарын эрх зүйн зохицуулалтыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна.

Иймд салбарын бодлого, усны нөөцийн тогтвортой менежмент, ус хангамжийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах чиглэлээр хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэв.

9.1 Хуулийн зорилт, бодлогын хүрээг өргөжүүлэх

Одоо мөрдөгдөж буй хууль нь хот, суурины ус хангамж, бохир ус зайлуулах, цэвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилготой боловч усны нөөцийн урт хугацааны тогтвортой ашиглалт, усны эрэлт нийлүүлэлтийн менежмент, усны нөөцийн хомсдолын эрсдэлийг бууруулах бодлогын асуудал хуулийн зорилтын хүрээнд хангалттай тусаагүй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад хотжилт, хүн амын өсөлт нэмэгдэхийн хэрээр хот, суурины усны хэрэглээ тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна. Үүнтэй холбоотойгоор усны нөөцийн

ашиглалт, ус хангамжийн системийн хүчин чадалд үзүүлэх ачаалал нэмэгдэж байгаа нь усны нөөцийн тогтвортой менежментийн асуудлыг бодлогын түвшинд авч үзэх шаардлагатайг харуулж байна.

Иймд хуулийн зорилт, бодлогын хүрээг өргөжүүлж дараах асуудлыг тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Санал

- хуулийн зорилтыг усны нөөцийн тогтвортой ашиглалттай уялдуулах
- усны хэрэглээний үр ашиг, ус хэмнэлтийн бодлогыг тусгах
- бохир усны дахин ашиглалтыг бодлогын түвшинд тусгах
- усны нөөцийн урт хугацааны менежментийн асуудлыг зохицуулах
-

Хүлээгдэж буй үр дүн

- усны нөөцийн ашиглалтын үр ашиг нэмэгдэнэ
- усны нөөцийн хомсдолын эрсдэл буурна
- салбарын бодлогын уялдаа сайжирна

9.2 Институцийн зохицуулалтыг сайжруулах

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарт бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүргийг хэд хэдэн байгууллага хэрэгжүүлж байна. Гэвч хэрэгжилтийн үнэлгээний явцад салбарын байгууллагуудын чиг үүргийн уялдаа хангалтгүй, мэдээллийн нэгдсэн тогтолцоо сул, бодлого хэрэгжүүлэх механизм тодорхой бус зэрэг асуудал ажиглагдаж байна.

Эдгээр нөхцөл байдал нь салбарын бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тодорхой хүндрэл үүсгэж, зарим тохиолдолд байгууллагуудын чиг үүргийн давхардал бий болох нөхцөл бүрдүүлж байна.

Иймд салбарын институцийн зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

Санал

- салбарын байгууллагуудын чиг үүргийг илүү тодорхой болгох
- бодлого хэрэгжүүлэх институцийн уялдаа холбоог сайжруулах
- салбарын мэдээллийн нэгдсэн системийг бий болгох
- салбарын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх

Хүлээгдэж буй үр дүн

- бодлогын хэрэгжилт сайжирна

- байгууллагуудын хамтын ажиллагаа нэмэгдэнэ
- салбарын удирдлагын үр ашиг дээшилнэ

9.3 Усны үйлчилгээний тарифын тогтолцоог боловсронгуй болгох

Усны үйлчилгээний тариф нь ус хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн механизм юм. Гэвч практикт усны үйлчилгээний тариф нь зарим тохиолдолд бодит өртгийг бүрэн тусгадаггүй нөхцөл ажиглагдаж байна.

Үүний улмаас усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт, шугам сүлжээний засвар үйлчилгээ, технологийн шинэчлэлийг санхүүжүүлэхэд хүндрэл үүсэх нөхцөл бүрдэж байна.

Иймд тарифын бодлогыг дараах чиглэлээр боловсронгуй болгох шаардлагатай.

Санал

- тариф тогтоох аргачлалыг шинэчлэх
- тарифыг бодит өртөгт тулгуурлан тогтоох
- ус хэмнэлтийн эдийн засгийн механизмыг нэвтрүүлэх
- дэд бүтцийн шинэчлэлийн санхүүжилтийг дэмжих механизм бий болгох

Хүлээгдэж буй үр дүн

- салбарын санхүүгийн тогтвортой байдал сайжирна
- дэд бүтцийн шинэчлэл эрчимжинэ
- усны хэрэглээний зохистой менежмент бий болно

9.4 Бохир усны дахин ашиглалтын зохицуулалтыг бий болгох

Хот, суурины бохир ус цэвэрлэх байгууламжаас гарч буй цэвэрлэгдсэн ус нь үйлдвэрлэлийн болон техникийн зориулалтаар ашиглах боломжтой нөөц гэж үзэж болно. Гэсэн хэдий ч Монгол Улсад бохир ус дахин ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, стандарт, техникийн шаардлага хангалттай хөгжөөгүй байна.

Олон улсын туршлагаас харахад бохир усны дахин ашиглалт нь усны нөөцийн ашиглалтыг сайжруулах, газрын доорх усны олборлолтыг бууруулах, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангах чухал бодлогын хэрэгсэл болдог.

Иймд бохир ус дахин ашиглах чиглэлээр дараах зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Санал

- бохир усны дахин ашиглалтыг эрх зүйн хүрээнд зохицуулах
- дахин ашиглах усны чанарын стандарт тогтоох

- үйлдвэрлэлийн хэрэглээнд дахин ашиглах ус ашиглах боломжийг дэмжих
- дахин ашиглах усны дэд бүтцийг хөгжүүлэх

Хүлээгдэж буй үр дүн

- усны нөөцийн ашиглалтын үр ашиг нэмэгдэнэ
- газрын доорх усны олборлолт буурна
- үйлдвэрлэлийн усны найдвартай эх үүсвэр бий болно

9.5 Ус хангамжийн дэд бүтцийн шинэчлэлийг дэмжих зохицуулалт

Хот, суурины ус хангамжийн системийн шугам сүлжээний элэгдэл, технологийн хоцрогдол нь ус хангамжийн үйлчилгээний найдвартай байдал, үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

Иймд ус хангамжийн дэд бүтцийн шинэчлэлийг дэмжих бодлогын зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Санал

- ус хангамжийн дэд бүтцийн шинэчлэлийн бодлогыг тодорхой болгох
- салбарын хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулах
- төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх
- олон улсын санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах

Хүлээгдэж буй үр дүн

- ус хангамжийн системийн найдвартай байдал нэмэгдэнэ
- усны алдагдал буурна
- салбарын технологийн шинэчлэл хурдасна

9.6 Нэгдсэн бодлогын санал

Хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд дараах бодлогын шийдвэрийн хувилбаруудыг дэвшүүлж байна.

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
2. Салбарын институцийн зохицуулалтыг боловсронгуй болгох
3. Усны нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих бодлогын зохицуулалтыг хөгжүүлэх
4. Бохир усны дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг бий болгох

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах боломж бүрдэх юм.

АРАВДУГААР БҮЛЭГ

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн энэхүү үнэлгээ нь хуулийн зохицуулалт салбарын бодит нөхцөл байдалтай хэрхэн нийцэж байгаа, түүний хэрэгжилт нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ямар үр дагавар үзүүлж байгааг тодорхойлох зорилготой байв.

Үнэлгээний хүрээнд хуулийн хэрэгжилтийг зорилгод хүрсэн түвшин, зардлын өөрчлөлт, зардал–үр өгөөжийн харьцаа, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр үнэлж, салбарын өнөөгийн нөхцөл байдал, институцийн зохион байгуулалт, эдийн засгийн хүчин зүйлс, техник технологийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийв.

Судалгааны үр дүнгээс харахад хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарт эрх зүйн үндсэн зохицуулалт бүрдсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийн хүрээнд ус хангамжийн үйлчилгээний тогтолцоо тодорхой хэмжээнд хөгжсөн байна. Хот, суурины хэрэглэгчдийг ундны болон ахуйн хэрэглээний усаар хангах нөхцөл сайжирч, ариутгах татуургын системийн хүрээнд бохир ус цэвэрлэх дэд бүтэц бий болсон нь нийгмийн эрүүл ахуй, байгаль орчны хамгаалалд эерэг нөлөө үзүүлж байна.

Гэсэн хэдий ч салбарын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд усны нөөцийн тогтвортой ашиглалт, хаягдал усны менежмент, салбарын санхүүжилт, институцийн зохион байгуулалтын хүрээнд тодорхой хүндрэл, бэрхшээлүүд байсаар байна.

Нэгдүгээрт, хотжилт, хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр хот, суурины усны хэрэглээ эрчимтэй өсөж байгаа нь усны нөөцөд үзүүлэх ачааллыг нэмэгдүүлж байна. Ялангуяа томоохон хотуудын ус хангамж нь газрын доорх усны нөөцөөс хамааралтай байгаа нь усны нөөцийн тогтвортой байдлыг хангах асуудлыг бодлогын түвшинд авч үзэх шаардлагатайг харуулж байна.

Хоёрдугаарт, бохир усны цэвэрлэгээний дараах усыг дахин ашиглах боломж хангалттай байгаа боловч эрх зүйн зохицуулалт, технологийн стандарт, эдийн засгийн механизм хангалттай хөгжөөгүй байгаа нь усны нөөцийг үр ашигтай ашиглах боломжийг бүрэн ашиглахгүй байх нөхцөл болж байна.

Гуравдугаарт, ус хангамж, ариутгах татуургын дэд бүтцийн зарим хэсэгт шугам сүлжээний элэгдэл, техник технологийн хоцрогдол ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь усны алдагдал нэмэгдэх, системийн үр ашиг буурахад нөлөөлж байна. Дэд бүтцийн шинэчлэл, өргөтгөлд шаардлагатай хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь салбарын хөгжлийг хязгаарлах хүчин зүйлсийн нэг болж байна.

Дөрөвдүгээрт, салбарын институцийн зохион байгуулалтын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо хангалтгүй байгаа нь бодлогын хэрэгжилтэд тодорхой хүндрэл үүсгэж байна. Салбарын мэдээллийн нэгдсэн

системийн хөгжил хангалтгүй байгаа нь бодлогын шийдвэр гаргалтыг мэдээллийн бодит суурь дээр хийхэд саад болж байна.

Тавдугаарт, усны үйлчилгээний тарифын тогтолцоо нь зарим тохиолдолд бодит өртгийг бүрэн тусгаж чаддаггүй бөгөөд энэ нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж байна. Үүний улмаас дэд бүтцийн шинэчлэл, технологийн сайжруулалт, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрдүүлэхэд хүндрэл үүсч байна.

Иймд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор эрх зүйн зохицуулалтыг салбарын хөгжлийн шинэ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, институцийн зохион байгуулалтыг сайжруулах, санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, усны нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжих бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэхүү үнэлгээний үр дүн нь хот, суурины ус хангамж, ариутгах татуургын салбарын бодлогыг цаашид боловсронгуй болгох, хууль тогтоомжийг шинэчлэх, салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох шийдвэр гаргалтад ашиглагдах боломжтой юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Хууль тогтоомжийн тухай хууль. 2015.
3. Усны тухай хууль. 2012.
4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2011, нэмэлт өөрчлөлтийн хамт.
5. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль. 2012.
6. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 1995.
7. Барилгын тухай хууль. 2016.
8. Зөвшөөрлийн тухай хууль. 2022.
9. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль. 2024.
10. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2020.

Хоёр. Хууль тогтоомжийн үнэлгээ, судалгааны арга зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.
2. “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал.” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралт.
3. “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт.
4. Хууль зүй, дотоод хэргийн яам. Хууль тогтоомж боловсруулах, үнэлэх арга зүйн гарын авлага.
5. Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэн. Хууль тогтоомжийн үнэлгээний судалгааны арга зүйн материал.

Гурав. Төрийн бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.
2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр.
3. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан усны нөөц, ус хангамж, ариутгах татуургын салбарын зорилт, арга хэмжээ.
4. Усны салбарын талаар төрөөс баримтлах бодлого, холбогдох дунд хугацааны хөтөлбөрүүд.
5. Ногоон хөгжлийн бодлого.
6. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030.

Дөрөв. Судалгааны тайлан, үнэлгээний баримт бичиг

1. Хууль, эрх зүйн хөгжлийн хүрээлэн. *Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.* 2018.

2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын судалгаа. 2026.
3. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал.
4. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.
5. Усны салбарын хэрэгжилт, үр дагаврын болон бодлогын үнэлгээний холбогдох тайлангууд.
6. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, дотоод мэдээлэл.

Тав. Салбарын статистик, мэдээллийн эх сурвалж

1. Үндэсний статистикийн хороо. Байгаль орчны статистикийн эмхэтгэлүүд.
2. Усны газар. Усны нөөц, ус ашиглалт, усны менежментийн статистик мэдээлэл.
3. Ус сувгийн удирдах газар. Улаанбаатар хотын ус хангамж, бохир усны үйлчилгээний статистик мэдээлэл.
4. Барилга, хот байгуулалтын яам. Салбарын бодлого, хэрэгжилтийн тайлан.
5. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах байгууллагын тайлан, мэдээ.
6. Аймаг, нийслэлийн ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын статистик мэдээ.
7. Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, ашиглалтын талаарх салбарын мэдээлэл.
8. Усны хэрэглээ, бохир усны хэмжээ, цэвэрлэгдсэн усны мэдээллийн сангууд.

Зургаа. Олон улсын байгууллагын тайлан, судалгаа

1. World Bank. *Wastewater Reuse in Cities: Opportunities, Challenges and Policy Considerations*.
2. Asian Development Bank. *Asian Water Development Outlook*.
3. UN-Water. *Global Water Security and Sanitation Partnership* тайлангууд.
4. WHO. Drinking-water, sanitation and wastewater management-тэй холбоотой удирдамж, техникийн баримт бичгүүд.
5. OECD. *Water Governance Indicators and Policy Framework*.
6. FAO. *Water reuse and irrigation management-тэй холбоотой техникийн тайлангууд*.

Долоо. Олон улсын туршлагын эх сурвалж

1. Israel Water Authority. Усны дахин ашиглалт, усны нөөцийн менежментийн тайлан, мэдээлэл.
2. PUB, Singapore. NEWater programme-ийн танилцуулга, бодлогын баримт бичиг.
3. Australia Water Services Association болон холбогдох усны байгууллагын судалгаа.
4. United States Environmental Protection Agency (EPA). *Water reuse, wastewater management-тэй холбоотой удирдамж, тайлан*.

5. Усны дахин ашиглалтын эрх зүйн зохицуулалтын олон улсын харьцуулсан судалгаанууд.

Найм. Цахим эх сурвалж

1. Legalinfo.mn — хууль тогтоомжийн нэгдсэн сан.
2. 1212.mn — Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн сан.
3. Усны газрын албан ёсны цахим хуудас.
4. Барилга, хот байгуулалтын яамны албан ёсны цахим хуудас.
5. Ус сувгийн удирдах газрын албан ёсны цахим хуудас.
6. Олон улсын байгууллагуудын албан ёсны цахим хуудас, мэдээллийн сангууд.

1.1.Хууль хэрэгжихээс өмнөх ба дараах нөхцөл байдлын харьцуулалт

Үзүүлэлт	Хууль батлагдахаас өмнө	Хууль хэрэгжиж эхэлснээс хойш
Ус хангамжийн үйлчилгээний зохицуулалт	Салбарын зохицуулалт харьцангуй сул, институцийн бүтэц тодорхой бус	Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний эрх зүйн зохицуулалт тодорхой болсон
Институцийн зохион байгуулалт	Байгууллагуудын чиг үүргийн хуваарилалт тодорхой бус	Салбарын бодлого, зохицуулалтын байгууллагуудын бүрэн эрх тодорхой болсон
Ус хангамжийн дэд бүтэц	Дэд бүтцийн хөгжил харьцангуй хязгаарлагдмал	Томоохон хотуудад дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэл хийгдсэн
Бохир усны менежмент	Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, зохицуулалт сул	Бохир ус цэвэрлэх байгууламжийн тогтолцоо тодорхой хэмжээнд хөгжсөн
Ус дахин ашиглах зохицуулалт	Эрх зүйн зохицуулалт бараг байхгүй	Дахин ашиглах бодлогын шаардлага тодорхой болсон боловч зохицуулалт хангалтгүй хэвээр

Эх сурвалж: Судалгааны багийн дүн шинжилгээ

1.2.Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээний матриц

Үнэлгээний чиглэл	Эерэг үр нөлөө	Сөрөг үр нөлөө	Ерөнхий үнэлгээ
Эдийн засгийн	Усны үйлчилгээний зохицуулалт тодорхой болсон	Тариф бодит өртгийг бүрэн тусгахгүй	Дунд
Нийгмийн	Ус хангамжийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн	Зарим бүсэд үйлчилгээний хүртээмж хангалтгүй	Дунд
Байгаль орчны	Бохир ус цэвэрлэх тогтолцоо бий болсон	Усны нөөцийн дарамт нэмэгдэх эрсдэл	Дунд
Институцийн	Салбарын зохицуулалтын бүтэц бий болсон	Байгууллагуудын уялдаа холбоо сул	Дунд

Эх сурвалж: Судалгааны багийн үнэлгээ

Схем 1.1. Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний нэгдсэн дүгнэлтийн диаграмм



Энэхүү диаграмм нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг эдийн засаг, нийгэм, байгаль орчин, институцийн чиглэлээр нэгтгэн харуулж байна.

1.3. Бодлогын шийдвэрийн хувилбарын матриц

Бодлогын асуудал	Одоогийн нөхцөл байдал	Боломжит бодлогын шийдэл	Хүлээгдэж буй үр нөлөө
Усны нөөцийн тогтвортой ашиглалт	Усны хэрэглээ өсөж, газрын доорх усны нөөцөд дарамт нэмэгдэж байна	Усны хэрэглээний менежментийг сайжруулах, ус хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх	Усны нөөцийн ашиглалтын үр ашиг нэмэгдэнэ
Бохир усны дахин ашиглалт	Эрх зүйн зохицуулалт тодорхой бус	Дахин ашиглах усны стандарт, зохицуулалт бий болгох	Усны нөөцийн ачаалал буурна
Институцийн зохион байгуулалт	Байгууллагуудын уялдаа сул	Институцийн зохицуулалтыг тодорхой болгох	Бодлогын хэрэгжилт сайжирна
Санхүүжилтийн тогтолцоо	Тариф бодит өртгийг бүрэн тусгахгүй	Тарифын тогтолцоог шинэчлэх	Салбарын санхүүгийн тогтвортой байдал сайжирна
Дэд бүтцийн шинэчлэл	Шугам сүлжээний элэгдэл өндөр	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, PPP механизм ашиглах	Үйлчилгээний чанар сайжирна

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулалт

1.4.Монгол Улсын хот, суурины ус хангамжийн статистик мэдээлэл

Монгол Улсын хот, суурины ус хангамжийн үйлчилгээ нь хүн амын унд, ахуйн хэрэгцээг хангах үндсэн дэд бүтцийн үйлчилгээний нэг бөгөөд усны хэрэглээ жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Хот, суурины ус хангамжийн үйлчилгээний статистик мэдээлэл нь усны хэрэглээний бүтэц, усны нөөцийн ашиглалтын түвшин, салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Монгол Улсын хотуудын усны хэрэглээ

Хот	Хүн ам	Хоногийн усны хэрэглээ
Улаанбаатар	~1.7 сая	150–170 мян.м ³
Дархан	~110 мянга	20–25 мян.м ³
Эрдэнэт	~100 мянга	18–22 мян.м ³

Эх сурвалж: Ус сувгийн удирдах газар

1.5.Хот, суурины бохир усны хэмжээ

Хотын усны хэрэглээнээс үүссэн бохир ус нь ариутгах татуургын шугам сүлжээгээр дамжин цэвэрлэх байгууламжид хүргэгдэж, боловсруулалт хийсний дараа байгаль орчинд нийлүүлэгддэг.

Хотын бохир усны ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжээ
Хоногийн бохир ус	~160 мянган м ³
Жилийн бохир ус	~58 сая м ³

Эх сурвалж: Салбарын 2024 оны статистик